

Аврахаам эцэг

2-р хичээл

Аврахаамын амьдрал:
Эх утга
(Пентатекийн 7-р хичээл)

Эх бичвэр



thirdmill

Biblical Education. For the World. For Free.

© 2012 Гуравдахь мянган жил үйлчлэл

Зохиогчийн бүх эрх хуулиар хамгаалагдсан. Энэ хэвлэлийн ямар ч хэсгийг ашиг олохын төлөө ямар нэгэн хэлбэрээр өөрчлөхийг хориглоно. Харин дүгнэлт бичих, санал өгөх, эрдэм шинжилгээний зорилгоор хэсэгчлэн эш татахад зохиогчийн эрхийг эзэмшигчээс бичгээр зөвшөөрөл авахыг шаардахгүй, Third Millennium Ministries, Inc., 316 Live Oaks Blvd., Casselberry, Florida 32707.

Энэхүү материалыг 2007 онд Ийгли ТВ-н Христийн Нэвтрүүлгийн албанд орчуулсан бөгөөд Библийн зарим эшлэлүүдийг Монголын Библийн Нийгэмлэгийн Шинэ Гэрээ ©1990 Эхлэл, номноос зохиогчийн зүгээс Ийгл ТВ-ын Христийн нэвтрүүлгийн албанд өгсөн зөвшөөрлийн дагуу оруулсан.

Библийн бусад эшлэлийг Ариун Бичээс Нийгэмлэгийн Ариун Библи ©2004-ээс авлаа.

ГУРАВ ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛИЙН ТУХАЙ

ДАХЬ МЯНГАН ҮЙЛЧЛЭЛ нь 1997 онд ҮҮСГЭН БАЙГУУЛАГДСАН, АШГИЙН БУС, ХРИСТИТГЭЛИЙН САЙНМЭДЭЭНИЙ ҮЙЛЧЛЭЛ БӨГӨӨД ДАРААХ ТАЛБАНУУДАД ЧИГЛЭДЭГ:

БИБЛИЙН БОЛОВСРОЛЫГ. БҮХ ДЭЛХИЙД. ҮНЭГҮЙ.

Бидний зорилго бол үйлчлэлд нь тохирсон сургалт хэрэгтэй байгаа зуу зуун, мянга мянган пастор, удирдагч нарт Христитгэлийн боловсролыг үнэгүй олгох явдал юм. Бид энэхүү зорилгодоо хүрэхийн тулд олон нийтийн мэдээллийн хэрэгслийг ашиглан, дахин давтагдашгүй, цуврал хичээлүүдийг Англи, Араб, Мандарин, Орос болон Испани хэл дээр бэлтгэн дэлхий дахинд түгээж байна. Мөн манай хөтөлбөрүүд хамтран ажилладаг үйлчлэлүүдээр маань дамжуулан өөр олон орны хэл уруу орчуулагдаж байгаа билээ. Хөтөлбөр бүр зурагт мэдээлэл бүхий бичлэг, дүрст заавар болон цахим эх сурвалжуудаас бүрдсэн байдаг. Эдгээр нь сургууль, бүлгүүд, хувь хүмүүс танхимаар болон цахимаар ашиглахад зориулагдсан болно.

Дээд зэргийн агуулга болон чанартай шилдэг олон нийтийн мэдээллийн хэрэгсэл бүхий хичээлүүдийг хамгийн хямд зардлаар бүтээх аргыг бид олон жилийн хугацаанд боловсруулсан. Манай зохиолч, хянан тохиолдуулагчид теологийн мэргэжлийн сургагч багш нар байдаг бөгөөд орчуулагчид нь орон нутгийнхаа унаган хэлтэй теологийн мэдлэгтэй хүмүүс байдгаараа давуу талтай. Мөн дэлхийн өнцөг булан бүрийн нэр хүндтэй эрдэмтэд болон номлогчдын үг манай хичээлүүдэд гүн шингэсэн байдаг. Үүнээс гадна зураглаач болон эх бэлтгэгч нар маань мэргэжлийн түвшний тоног төхөөрөмж болон арга хэрэгслийг ашиглан өндөр чанарын бүтээл гаргахаар зорьдог билээ.

Бүтээлүүдээ дэлхий дахинд түгээхийн тулд Гурав дахь мянган үйлчлэл нь сүм чуулганууд, сургалтууд, Библийн сургуулиуд, илгээлтийн эзэд, Христитгэлийн нэвтрүүлэгчид болон өргөн нэвтрүүлгийн сувгууд гэх мэт олон төрлийн байгууллагуудтай бодлогын түншлэлийг бий болгосоор ирсэн. Энэхүү бодлогын түншлэлийн үр дүнд тоо томшгүй олон дүрст бичлэг бүхий хичээлүүд нь орон орны уугуул удирдагч нар, пасторууд болон оюутнуудад хүрчээ. Мөн бид цахим хуудсаараа дамжуулан суралцах бүлгээ хэрхэн эхлүүлэх зэрэг хичээлүүдийг баяжуулах нэмэлт хэрэглэгдэхүүнүүдийг тараан түгээсээр байна.

Гурав Дахь Мянган Үйлчлэл нь татвараас чөлөөлөгдөх зөвшөөрөлтэй (IRS as a 501(c) (3) corporation). Бид сүм чуулганууд, сангууд, аж ахуйн нэгж болон хувь хүмүүсийн татвараас чөлөөлөгдсөн өгөөмөр хандиваар үйл ажиллагаагаа явуулдаг. Манай үйлчлэлийн тухай болон хамтран ажиллах талаар дэлгэрэнгүй мэдээлэл авахыг хүсвэл <https://www.thirdmill.org> цахим хуудсаар зочлоорой.

Аврахаам эцэг
Хоёрдугаар хичээл
Аврахаамын амьдрал: Эх утга

Гарчиг

Удиртгал	1
Холбоосууд	2
Тодорхойлолт	3
Төрлүүд	4
нөхцөл байдал	4
үлгэр дууриал	5
урьдчилсан дохио	7
Хураангуй дүн	9
Далд санаа	10
Үндсэн нөлөө	10
Үндсэн сэдвүүд	11
Ертөнцийн Эзэний хайр өршөөл	11
Аврахаамын үнэнч байдал	12
Аврахаамд өгсөн сайн сайхан зүйлс	13
Аврахаамаар дамжин ирэх сайн сайхан зүйлс	14
Таван үе шат	15
Уг гарал ба эхний харилцаа	15
Бусад хүмүүстэй харилцсан эхний харилцаа	16
Ертөнцийн Эзэнтэй тогтоосон гэрээ	17
Бусад хүмүүстэй харилцсан хожмын харилцаа	18
Үр хүүхдүүд ба үхэл	20
ДҮГНЭЛТ	22
ҮГСИЙН ТАЙЛБАР	24

Аврахаам эцэг

Хоёрдугаар хичээл

Аврахаамын амьдрал: Эх утга

УДИРТГАЛ

Христийн үнэнч дагалдагчид Ертөнцийн Эзэний сургаалд хайртай байдаг. Түүний сургаал нь бидний амьдралыг олон янзын байдлаар, тун хувьчилан өгүүлсэн байдгийг бид олж мэддэг. Энэ бол Христэд итгэгчдийн хэзээ ч мартаж болохгүй Библийн тухай хамгийн үнэтэй үнэн юм. Гэхдээ олон удаа Ертөнцийн Эзэний сургаалийн хувь хүнд хандсан энэ гайхалтай тал нь бидний санаж байх ёстой нэг зүйлийг мартахад хүргэдэг. Библийг танд болон надад шууд хандан бичээгүй гэдгийг бид үргэлж санаж байх ёстой. Юуны өмнө Библийг олон мянган жилийн өмнө амьдарч байсан хүмүүст зориулж бичсэн юм. Тийм учраас бид Библийг өнөөгийн амьдралдаа хэрхэн хэрэгжүүлэхийг ойлгох гэж хичээхдээ түүний эх утгыг орчин үед хэрэглэх талаар үргэлж маш болгоомжтой хандаж байх хэрэгтэй.

Энэ бол “Аврахаам эцэг” гэж бидний нэрлэсэн цуврал хичээл юм. Бид энэ хичээлээр Эхлэл номын 11-р бүлгийн 10-аас 25-р бүлгийн 18-д гарах Аврахаамын амьдралын тухай баримтыг судлана.

Харин энэ бол дээрх гурван танилцуулга хичээлийн хоёр дахь нь юм. Бид үүнийг “Аврахаамын амьдрал: Эх утга” гэж нэрлэлээ. Бид энэ хичээлээр Аврахаамын амьдралын түүхийг уншихдаа үүнийг хэзээ бичсэн, хэнд хандан бичсэн гэдгийг ойлгож унших нь ямар их чухал болохыг үзэх болно. Бид бас энэ түүх нь Израйльчуудад, Мөшэхийг дагаж Ертөнцийн Эзэний амласан нутаг уруу явж байхад ямар нөлөө үзүүлэх ёстой байсныг судлана.

Эхлэлийн 11-р бүлгийн 10-аас 25-р бүлгийн 18-р хүртэлх хэсгийн эх утгыг үзэхдээ 2 гол асуудлыг судлах болно. Нэгдүгээрт, бид Аврахаамын амьдралын түүхийг Мөшэх хэрхэн өөрийнх нь үгийг унших анхны уншигчдынхаа амьдрал байдалтай холбож байгааг үзнэ. Хоёрдугаарт, эдгээр холбоос нь Мөшэхийн анхны уншигчдад ямар далд санааг илэрхийлж байгааг үзнэ.

Бүгдээрээ Аврахаамын амьдралын түүхийн эх утгыг судлахаасаа өмнө эхний хичээлд үзсэн зүйлсээ дахин нэг тоймлож үзэцгээе. Өдий хүртэл бид хоёр гол асуудал дээр гол анхаарлаа хандуулсан билээ. Эхлээд бид Эхлэлийн 12-р бүлгийн 1-ээс 3-т өгүүлэх Аврахаамын түүхээс дөрвөн гол сэдэв буюу санаа гарч байгааг үзсэн. Аврахаамд үзүүлсэн Ертөнцийн Эзэний сайхан сэтгэл. Израйлийн энэ алдарт өвөгт Ертөнцийн Эзэн энэрэл хайраа харамгүй үзүүлсэн билээ. Ертөнцийн Эзэнд үнэнч байх Аврахаамын хариуцлага. Ертөнцийн Эзэн Аврахаамыг өөрт нь олон талаар дуулгавартай байхыг хүсэж байв. Аврахаамд өгсөн Ертөнцийн Эзэний сайн сайхан зүйлс. Түүнд агуу үндэстэн, олон үр хүүхэд, газар нутаг болон өндөр нэр хүнд өгөхөөр амласан билээ. Аврахаамаар дамжин бусад хүнд ирэх Ертөнцийн Эзэний сайн сайхан зүйлс. Аврахаам энэ дэлхийн бүх гэр бүлд Ертөнцийн Эзэний ивээл болно гэсэн амлалт.

Үүнээс гадна эдгээр үндсэн сэдэв нь Эхлэл номонд өгүүлэх Аврахаамын түүхийг бүрдүүлсэн болохыг бид бас харсан. Бид Аврахаамын амьдрал нь таван тэгш хэмт буюу тэнцвэртэй үе шатаас бүрдэж байгааг үзсэн. Эхнийх нь, 11-р бүлгийн 10-

аас 12-р бүлгийн 9-д гарч буй Аврахаамын уг гарал болон Ертөнцийн Эзэнтэй харилцсан анхны харилцаа юм. Хоёрдахь нь, 12-р бүлгийн 10-аас 14-р бүлгийн 24-т гарах хэдэн үйл явдал бөгөөд энэ нь бусад хүмүүстэй харилцсан Аврахаамын эхний харилцаан дээр төвлөрдөг. Гуравдахь нь буюу Аврахаамын амьдралын гол хэсэг түүнтэй байгуулсан Ертөнцийн Эзэний гэрээнд төвлөрч байгааг 15-р бүлгийн 1-ээс 17-р бүлгийн 27-д бичжээ. Аврахаамын амьдралын дөрөвдэхь шат бол түүний бусад хүмүүстэй харилцсан хожмын харилцаа бөгөөд энэ тухай 18-р бүлгийн 1-ээс 21-р бүлгийн 34-д бичсэн байдаг. Харин тавдахь шат нь Аврахаамын бусад үр хүүхэд ба үхлийн тухай өгүүлсэн хэсэг бөгөөд үүнийг 22-р бүлгийн 1-ээс 25-р бүлгийн 18-д бичсэн байдаг.

Энэ 5 шат нь энэ алдарт өвгийн амьдралыг тэгш хэмт байдлаар танилцуулдаг. 15-р бүлгийн 1-ээс 17-р бүлгийн 27-г хамарсан гуравдахь хэсэг нь Аврахаамтай тогтоосон Ертөнцийн Эзэний гэрээний тухай өгүүлдэг бөгөөд түүний амьдралын хамгийн гол хэсэг болж ордог юм. Тэгвэл хоёрдахь болон дөрөвдэхь хэсгүүд нь бусад хүнтэй харилцсан Аврахаамын харилцаан дээр гол анхаарлаа хандуулсан байдгаараа хоорондоо төстэй байдаг. Харин эхний болон сүүлчийн хэсэг нь Аврахаамын гэр бүлийн өнгөрсөн болон ирээдүйг мөшгөж, түүний амьдралын эхлэл төгсгөлийг өгүүлсэнээрээ хоорондоо төстэй байдаг юм.

Тэгэхлээр олон талаараа өнөөдрийн хичээл нь Аврахаамын амьдралын түүхийг өгүүлсэн хэсгийн бүтэц ба агуулгыг ухааран ойлгуулсан энэ бүх ойлголтоос бүрдэж байна. Бид энэ бүхнийг сэтгэлдээ тунгаан бодоод Эхлэл номонд өгүүлэх Аврахаамын амьдралын тухай өгүүлсэн хэсгийн эх утга гэсэн хичээлээ судлахад бэлэн боллоо. За одоо бүгдээрээ Аврахаамын тухай түүх болон энэ түүхийг анх сонссон Израйльчуудын туулсан амьдралын хоорондын холбоосыг судалж эхэлцгээе.

ХОЛБООСУУД

Бид Аврахаамын амьдралыг тайлбарлаж буй эдгээр цуврал хичээлээ, энэ бүх түүх нь анх Мөшэхийн үед бичигдсэн бөгөөд ерөнхийдөө одоо ч гэсэн тухайн үеийнх шиг утга агуулгатай хэвээр байгаа гэдэг үзэл баримтлал дээр үндэслэж бэлтгэсэн юм. Аливаад шүүмжлэлттэй ханддаг ихэнх эрдэмтэд энэ бүх түүхийг Мөшэхийн амьдарч байх үед бичээгүй гэж үздэг ч Хуучин Гэрээний зарим хэсэг болон Есүс өөрөө хүртэл Эхлэл номыг Мөшэх бичсэн гэж шаргуу нотолдог. Тийм учраас өнөөгийн Христэд итгэгчид бид энэ номын зохиогч Мөшэх гэдгийг хүлээн зөвшөөрөх хэрэгтэй. Бид энэ цуврал хичээлээр үүнийг улам гүнзгийрүүлж үзнэ. Бид Мөшэх эдгээр түүхийг бичсэн гэдэг баримтыг л ойлгох бус, тэдгээрийг яагаад бичсэн гэдгийг мэдэхийг хүсэж байна. Тэрбээр Аврахаамын амьдралын талаар ямар үзэл бодолтой байв? Энэ бүхнийг ямар зорилгоор бичив ээ? Аврахаамын амьдралын тухай хэсгийн эх утгыг судалж эхлэх хамгийн сайн арга бол Мөшэх Аврахаамын тухай түүхийг өөрийг нь дагаж Египетээс гараад Амласан нутаг руу явж байгаа анхны уншигчид болох Израйльчуудын үзэж туулж буй бүхэнтэй хэрхэн холбож

байгааг үзэх явдал юм.

Мөшэх Аврахаамын тухай түүхийг анхныхаа уншигчидтай хэрхэн холбож байгааг судлахын тулд бид гурван асуудлыг авч үзэх болно. Эхлээд, бид холбоосууд гэж юуны тухай хэлж байгаагаа тодорхойлно. Хоёрдугаарт, бид Аврахаамын амьдралын түүхээс харагдаж буй зарим төрлийн холбоосыг үзнэ. Гуравдугаарт, бид Аврахаамын амьдралын түүхийг бүрдүүлж буй 5 гол үе шат бүрийг харж эдгээр холбоосоо хураангуйлна. За одоо бүгдээрээ холбоосууд гэж юуг хэлээд байгаагаа үзэцгээе.

ТОДОРХОЙЛОЛТ

Мөшэх Аврахаамын амьдралын түүхийг бичихдээ олон талаараа библийн бүх хүүрнэл зохиогчдын орсон тийм л нөхцөл байдалд өөрөө орсон байна. Тэрбээр хоёр ертөнцийн дунд зогсож байлаа. Нэг талаар Мөшэх “тэр ертөнц” буюу Аврахаамын амьдарч байсан ертөнцөд амьдарч байлаа. Тэрбээр өвлөгдөж ирсэн түүх болон Ертөнцийн Эзэний ер бусын илчлэлтээр таваас зургаан зуун жилийн өмнө Аврахаамын амьдралд тохиолдсон явдлуудыг мэдсэн байна. Энэ утгаараа бол Мөшэх нь Аврахаамын аж төрж байсан эртний дэлхийд амьдарч байгаа хүн шиг болсон.

Нөгөө талаар Мөшэх нь өөрийнхөө үеийнхэний аж төрж байсан дэлхийд амьдарч байсан. Үүнийг бид “тэдний ертөнц” буюу Мөшэхийг дагаж явсан Израйльчуудын ертөнц гэж нэрлэж болох юм. Мөшэх тухайн үеийн Ертөнцийн Эзэний хүмүүсийн удирдагч байсныхаа хувьд “тэдний ертөнцийн” хэрэгцээ шаардлагыг хангахын тулд Аврахаамын амьдарч байсан эртний ертөнцийн тухай бичсэн билээ.

Тэгээд Мөшэх Аврахаамын амьдарч байсан үе буюу “тэр ертөнц” ба өөрийнхөө ертөнц хоёрын хооронд зуучлахдаа Израйлийн энэ алдарт өвгийн амьдралыг уншигчдынхаа амьдралтай холбож байна. Тэгснээр Израйльчууд түүний бичсэн түүх өөрсдийнхөө нь амьдралтай хамаатай байгааг ойлгож чадах байв. Нэг үгээр хэлбэл, Мөшэх өөрийг нь дагаж буй Израйльчууд, Аврахаамын амьдрал өөрсдийнх нь амьдралтай холбоотой гэдгийг харах боломж олгохын тулд эдгээр түүхийг сонгож уг номыг бичсэн байна. Үүнийг бүхэлд нь харах юм бол, Мөшэх ингэж бичсэнээр уншигчид нь Аврахаам болон өөрсдийнхөө үзэж туулж буй бүхний ижил төстэй ба ялгаатай талыг олж харах боломжтой болж байгаа юм. Заримдаа эдгээр ижил төстэй болон ялгаатай тал нь үл ялигхан байдаг. Заримдаа нилээд их байдаг. Гэхдээ Мөшэх тухайн хэсэг бүрт Аврахаамын амьдрал ба өөрийнхөө анхны уншигчдын хооронд буй иймэрхүү холбоосонд анхаарлаа хандуулсан байна.

Ийнхүү бид холбоосууд ба эх утгын талаар үндсэн ойлголттой боллоо. Одоо хоёрдахь асуудал болох Аврахаамын амьдрал ба анхны Израйль уншигчдын үзэж туулж буй зүйлсийн хоорондын холбоосын төрлийг үзэцгээе.

ТӨРЛҮҮД

Ямар ч түүхийг уншигчидад хамааралтай болгохын тулд тэдний ойлгож чадах ертөнцийг дүрслэх хэрэгтэй байдаг. Хэрэв тухайн түүхэнд гарч буй ертөнц нь бодит ертөнцөөс огт өөр байвал уншигчид нь тэнд гарах дүрүүд болон сэдвийг ойлгож чадахгүй. Ингэснээр уг түүхийн агуулгыг илэрхийлэх боломжгүй болно. Эсвэл Аврахаамын амьдарч байсан “тэр ертөнц” маань Мөшэх болон Израйльчуудын амьдарч байсан “тэдний ертөнцөөс” огт өөр байвал Аврахаамын тухай түүх нь Израйльчуудад ямар ч утга учиргүй санагдаж, тэдэнтэй ямар ч холбоогүй болно. Тийм учраас л Мөшэх Аврахаамын амьдарч байсан ертөнц ба Ертөнцийн Эзэний амласан нутаг руу явж байгаа Израйльчуудын ертөнцийг хооронд нь холбохыг маш их хичээсэн байдаг.

Тэгэхлээр Мөшэх эдгээр холбоог хир зэрэг тодорхой болгосон бэ гэдэг асуултыг энэ хичээл бидний өмнө тавьж байна. Тэрбээр хэрхэн Аврахаамын тухай түүхийг өөрийн уншигчдын ертөнцтэй холбож болохоор бичсэн бэ? Бид энэ цуврал хичээлээ үзэх явцдаа Мөшэх өөрийн тэмдэглэлээ Израйльчуудын үзэж туулж буй амьдралтай гурван байдлаар голлон холбосон байгааг харах болно. Нэгдүгээрт, тэрбээр Израйльчуудын үзэж туулж байгаа зүйлийн түүхэн нөхцөл байдлыг тэдэнд хэлэх зорилгоор тухайн үйл явдлуудыг бичсэн байна. Хоёрдугаарт, тэрбээр Израйльчуудад дагах эсвэл зайлсхийх үлгэр дууриал болон жишээ болгож хүүрнэл түүхүүдээ бичсэн байна. Гуравдугаарт, тэрбээр Аврахаамын үзэж туулсан олон зүйл нь Израйльчуудын үзэж туулж буй бүхнийг урьчилсан хэлсэн буюу битүүхэн дурдсан гэдгийг үзүүлэх гэж бичсэн юм. Бид дараагийн хичээлд иймэрхүү холбоосыг олон удаа дурдана. Тиймээс бид Аврахаамын амьдралыг өөрийнхөө анхны уншигчидтай хамааралтай болохыг харуулахын тулд Мөшэхийн хэрэглэсэн энэ гурван аргатай сайтар танилцах хэрэгтэй. Ингээд Мөшэхийн үед амьдарч байсан Израйльчуудын үзэж туулж байгаа бүхний түүхэн нөхцөл байдлыг Аврахаамын амьдрал хэрхэн харуулж байгааг үзэцгээе.

нөхцөл байдал

Энэ нь бүх холбоосоос таниж мэдэхэд хамгийн амархан нь юм.

Өөрсдийн үзэж туулж буй бүхний түүхэн нөхцөл байдлыг ухаж мэдэх зорилгоор бие биендээ янз бүрийн түүх ярих явдал ямар ч үндэстэний дунд түгээмэл байдаг. Эцэг эхчүүд хүүхдүүддээ иймэрхүү түүх ярьж өгдөг. Багш нар ч хичээлээ бас ийм аргаар заадаг. Пасторууд, түүгээр ч барахгүй алдартай улс төрчид ч гэсэн үүнийг ашигладаг. Олон удаа бид түүхэн нөхцөл байдлыг дурдаж сонсогчидынхоо анхаарлыг татаж байгаад аливаа түүхийг ярьдаг билээ.

Тэгэхлээр энэ холбоосыг Аврахаамын амьдралтай холбож дараах байдлаар тодорхойлж болно. Израйльчуудын үзэж туулж буй бүхэн нь Аврахаамын амьдралд тохиолдсон үйл явдлуудтай түүхэн үндэс нэгтэй гэдгийг Мөшэх заахдаа түүхэн нөхцөл байдлаар холбосон байна. Жишээ нь, Мөшэх Хинаан нутгийг Израйльчуудын төрөлх нутаг гэж үзэж болох асуудлыг түүхэн нөхцөл байдлаар

хэрхэн тайлбарлаж байгааг үзэцгээе. Израйльчууд Египетээс гарч нүүдэллэн явж байхдаа яагаад Хинаан нутаг руу явах ёстой гэдэгтээ олон удаа гайхан эргэлзэж байсныг та нар санаж байгаа байх. Яагаад Мөшэх тэднийг Ертөнцийн Эзэний амласан нутагт нэврэн оролгүй замдаа зогсохыг зөвшөөрөхгүй байсан бэ?

Яг энэ асуудалд Мөшэх нэлээд хэдэн удаа Аврахаамын амьдралын түүхэн нөхцөл байдлын талаар зарим нэг дэлгэрэнгүй баримтыг дурдаж хандсан байдаг. Нэг үгээр хэлбэл, Ертөнцийн Эзэн Аврахаамд орших суух газар нутгийг тусгайлан Хинаанд өгсөн гэдгийг тэрбээр харуулсан. Тийм учраас Мөшэх яагаад тэднийг Хинаанд эх нутагтай болно хэмээн шавдуулаад байсныг Израйльчууд ойлгох ёстой байлаа. Жишээлбэл, Эхлэлийн 15-р бүлгийн 18-д:

Энэ газар нутгийг би удам угсаанд чинь өгнө. Энэхүү газар нутаг нь Египетийн хил дээрх голоос эхлээд Евфрат мөрөн хүртэл үргэлжилнэ (Эхлэл 15:18).

Энэ хэсэг нь Израйльчууд Хинаан нутгийг эзлэн эзэгнэх ёстой гэж Мөшэхийн шаргуу шаардлагын үндэслэл буюу түүхэн нөхцөлийг бүрдүүлж байна. Ертөнцийн Эзэн тэр газар нутгийг Израйлийн агуу өвөгт өгсөн. Тэрбээр тэр газрыг түүний удам угсаа болсон Израйльчуудад бас өгсөн юм. Тиймээс тэд үүнээс өөр газар нутагт суурших ёсгүй ажээ.

Бид Аврахаамын амьдралыг улам бүр нарийвчлан үзэх бүр Мөшэх иймэрхүү түүхэн нөхцөл байдлын талаар олонтоо дурдаж байсныг харах болно. Аврахаамын амьдралыг өөрийнхөө үеийн Израйльчуудын амьдралтай холбож буй Мөшэхийн хоёрдахь гол арга бол тэдэнд үлгэр дууриал болох зүйлсийг харуулах явдал байв. Бүгдээрээ ийм үлгэр дууриалыг эдгээр түүхэнд хэрхэн оруулсаныг үзэцгээе.

ҮЛГЭР ДУУРИАЛ

Өөрийнх нь анхны уншигчид Аврахаамын тухай түүхийг зөвхөн нэг ерөнхий мэдээлэл маягаар хүлээж авахыг Мөшэх хүсээгүй. Тэрбээр Израйлийн энэ агуу өвгийн амьдралын олон үйл явдлыг дүрсэлсэн тул Израйльчууд түүний амьдрал болон өөрсдийнхөө амьдралын хооронд олон ижил төстэй нөхцөл байдал байгааг харсан байна. Иймэрхүү ижил төстэй байдал нь Аврахаамын тухай уншиж буй уншигчдын ёс суртахууны асуудлыг хөндөв. Энэ бүхэн Израйльчуудад даган дууриал эсвэл эсэргүүцэн татгалзах жишээ болгон харах боломж олгож байгаа тухай Мөшэх дурдаж байлаа.

Үлгэр дууриал эсвэл жишээ загвар болгох түүх ярих нь ярьж байгаа сэдвээ сонсогчиддоо хүргэх түгээмэл арга билээ. Хаа сайгүй л ингэдэг. Бид ажил дээрээ хэн нэгэн хүнд тэгж болохгүй ингэж болохгүй гэж хэлэхдээ урьд хэн нэгэн хүн тийм алдаа гаргаснаас болж юу болсон тухай түүхийг нэмж ярьдаг. Бид хүүхдүүддээ яагаад хичээлээ сайн давтах ёстой талаар сургахдаа яриагаа ихэвчлэн сургууль сурч байхдаа хичээлээ сайн давтаж байсан учраас өндөр амжилтанд хүрсэн хүмүүсийг жишээгээр баяжуулдаг.

Мөшэх ч хүртэл Аврахаамын түүхийг анхныхаа уншигчиддаа хүргэхийн тулд иймэрхүү аргыг олонтоо хэрэглэсэн. Тэрбээр Аврахаамын түүхэнд гарч буй дүрүүдийг Израйльчууд нэг бол даган дууриах эсвэл үгүйсгэн татгалзах байдлаар танилцуулсан байдаг. Мөшэх Хинаан нутгийг эзэмшиж байсан Хинаанчуудын заналхийлэлийн эсрэг зоригтой байхыг Израйльчуудаас хэрхэн шаардаж байсныг жишээ болгон авч үзье. Хинаанд амьдарч байсан Хинаанчууд хүчирхэг байсан тул Мөшэхийг дагаж байсан Израйльчууд тийшээ орохоос эмээж байсан тухай бид “Тооллого” болон “Дэд хууль” номноос уншсан. Хинаанчууд дийлдэшгүй дайсан мэт санагдаж байсан учраас тэд айж зүрх алдаж байлаа. “Дэд хууль” номын 1-р бүлгийн 26-аас 28-д Израйлийн овог аймгуудад хандан Мөшэх ингэж хэлдэг:

Гэвч та нар тийш явахаас дургүйцэж Ертөнцийн Мөнх Эзэнийхээ тушаалыг эсэргүүцлээ. Та нар майхандаа гомдоллож, “Мөнхийн Эзэн биднийг үзэн ядсан байна. Тийм учраас Тэрбээр биднийг Имөөр овгийнхоны гарт өгч устгахын тулд Египетээс чөлөөлсөн байна. Бид хаашаа явах вэ? Ах дүү нар маань, 'Хүмүүс нь биднээс аварга том, өндөр. Мөн хотууд нь маш том, тэнгэр тулсан өндөр' гэж хэлж бидний зүрхийг мохоосон ” гэж хэлсэн (Дэд хууль 1:26-28).

Хинаанчуудаас айх энэ айдсыг үгүй болгохын тулд Мөшэхийн хэрэглэсэн нэг арга бол уншигчиддаа тухайн үед Аврахаам Хинаанчуудтай хэрхэн нүүр тулж байсан жишээг дурдсан явдал юм. Жишээ нь бид Аврахаамын амьдралд Хинаанчууд орж ирсэн анхны тохиолдлыг Эхлэлийн 12-ийн 6-аас уншдаг:

Тэр үед Хинаан орныг Хинаан овог аймгийнхан эзэгнэж байв.
[Аврахаам] Хинааны өмнө зүгт . . . хоноглов (Эхлэл 12:6).

Үүнтэй төстэй жишээг Эхлэлийн 13-ийн 7-д:

Үүнээс гадна Хинаан болон Пэризи овог аймгийнхан тэнд суурьшиж байсан (Эхлэл 13:7).

Тэгвэл яагаад Мөшэх Хинаанчууд оршин сууж байсан тухай зэргэлдээ хоёр хэсэгт дурдав. Аврахаамын орсон нөхцөл байдал тэд нарынхтай төстэй гэдгийг харуулах нь түүний нэг зорилго байжээ. Хинаанчууд нь Мөшэх болон Израйльчуудын амьдарч байх үеийнх шиг Аврахаамыг амьдарч байх үед ч бас Амласан нутаг оршин сууж байсан юм. Хэдий тийм боловч Аврахаам Ертөнцийн Эзэний амлалтанд итгээд Хинаанчуудын эзэлсэн нутаг уруу зоригтой орсон билээ. Хэдийгээр тэр нутгийг Хинаанчууд эзэмшиж байсан ч Ертөнцийн Эзэний амлалтанд найдсан Аврахаамын эр зоригийг даган дууриахыг Мөшэх уншигчидаасаа хүсэн тэднийг зоригжуулж байлаа. Ийм байдлаар Аврахаам тэдний даган дууриах үлгэр жишээ болж байв.

Бид Аврахаамын амьдралыг нарийвчлан үзэж байхдаа эерэг болон сөрөг жишээ болохуйц олон хэсгийг унших болно. Гуравдугаарт, Мөшэх Аврахаамын амьдралыг уншигчдынхаа амьдралтай холбохын тулд энэ алдарт өвгийн амьдралд

тохиолдсон зүйлс тэдэнд тохиолдож буй үйл явдлыг хэрхэн урьдчилан буюу битүүхэн хэлснийг үзүүлсэн.

урьдчилсан дохио

Олон талаараа түүхэн нөхцөл байдал нь тухайн түүх ба үүний уншигчдын хооронд ижил төстэй байдлыг туйлын бага хэмжээтэй байхыг шаарддаг байна; Тэгвэл жишээ ба үлгэр дууриал нь тухайн түүх ба үүний уншигчдын хооронд илүү их ижил төстэй байдлыг шаарддаг. Өөрөөр хэлбэл жишээ нь уншигчидтай холбоотой байх ёстой. Харин урьдчилсан дохио болох зүйл ижил төстэй байдал олонтоо гарч байгаа үед л илэрдэг байна. Тэгэхлээр Аврахаамын “тэр ертөнц” нь Израйльчуудын “тэдний ертөнцтэй” бараг адилхан юм шиг харагдаж байна. Иймэрхүү өргөн хэмжээний хэлхээ холбоо Аврахаамын амьдралын түүхэнд тийм их хэмжээгээр гардаггүй. Гэхдээ Мөшэх Аврахаамын амьдарч байсан үеийг дүрслэхдээ аль болох өөрийн амьдарч байсан цаг үетэй ижил төстэй үйл явдлыг дахин дахин оруулж өгсөн байдаг.

Бидний олонхи маань “Түүх дахин давтагддаг” гэдэг хуучны үгийг сонссон. Мэдээж түүхэн хоёр үйл явдал хоорондоо яг адилхан байдаггүй гэдгийг бид бүгд мэднэ. Гэхдээ заримдаа түүхэн үйл явдлууд хооронд их адилхан байдаг. Бүр хоёрдахь үйл явдал нь эхнийхийгээ яг давтчихсан юм шиг санагддаг билээ. Библийн зохиогчид өнгөрсөн үед болсон үйл явдлууд уншигчдынх нь амьдралд давтагдаж байгааг харсан үедээ иймэрхүү холбоо хэлхээг маш тодорхой бичдэг байв. Утга зохиолын ийм аргыг урьдчилсан дохио гэж нэрлэдэг юм.

Ийм урьдчилсан дохионы нэг жишээг Эхлэлийн 15-р бүлгийн 1-ээс 21-нд буй Аврахаамтай байгуулсан Ертөнцийн Эзэний гэрээг өгүүлсэн алдартай хэсгээс харж болно. Ертөнцийн Эзэн Аврахаамд гэрээний ёслолд бэлтгэх үүрэг өгснөөрөө хэзээ нэгэн цагт түүний үр удам нь Хинаан нутгийг эзэмших болно гэдэг баталгаа өгсөн юм. Аврахаам хэдэн малыг өргөлд өргөхөөр нядалж махыг нь өрөөлдөөд зэрэгцүүлэн тавьдаг. Тэгээд нойрондоо дийлдэн нам унтсаныхаа дараа гэнэт сэргж нэгэн үзэгдэл үзсэн нь Мөшэхийн анхны уншигчдын туулж буй үйл явдалтай тун адилхан байлаа. Бид Эхлэлийн 15-р бүлгийн 17-д:

Тэгээд тэр шөнө нь гэнэт дүрэлзсэн их түүдэг гал асав. Галаас өтгөн их утаа багширч, хурц дөл цацарч байлаа. Өнөөх түүдэг гал ассаар, эгнүүлэн өрсөн өрөөл махнуудын дундуур явж өнгөрөв (Эхлэл 15:17).

Үүнийг илүү өргөн утгаар нь авч үзвэл нядалсан малын өрөөл махан дундуур Ертөнцийн Эзэн Өөрөө явж өнгөрсөнийг энэ багширсан өтгөн утаа, дүрэлцсэн хурц галаар төлөөлүүлсэн бөгөөд энэ бүхэн нь Тэрбээр энэ амлалтын нутгийг Аврахаамын үр удам гарцаагүй өгсөний баталгаа болж байна.

Тэгэхлээр үүний утгыг ойлгоцгооё. Эхлэлийн 15-ийн 17-д Ертөнцийн Эзэн энэ амласан нутгийг Аврахаамын үр удамд өгөхөө батлахын тулд түүний өмнө утаа болон гал болж явж өнгөрсөн байна. Орчин үеийн уншигч бидэнд Ертөнцийн Эзэн

Аврахаамд утаа болон гал болж харагдсан гэдэг нь хачин санагдаж магадгүй. Харин Мөшэх өөрийг нь дагаж Амласан нутаг руу явж байгаа Израйльчуудад хандан Аврахаамын амьдралын тухай бичиж байгаа учраас тэрбээр энэ бүхнийг дэлгэрэнгүй оруулж өгсөн нь бидний гайшралыг төрүүлэх ёсгүй ээ. Израйльчуудын аялалын турш Ертөнцийн Эзэн тэдний өмнө өтгөн их утаа, дүрэлзсэн галтай төстэй байдлаар харагдаж байсан билээ. Амласан нутаг руу тэднийг удирдаж байсан Ертөнцийн Эзэний яруу алдрыг илэрхүүлэх үүлэн дунд ч гэсэн Тэрбээр утаа гал болон харагдаж байлаа.

Тэгэхлээр Аврахаамд Ертөнцийн Эзэн иймэрхүү байдлаар үзэгдсэн нь Түүнийг Мөшэхийн амьдарч байх үеийн Израйльчуудад үзэгдэхийн урьдчилсан дохио болсон байна. Ертөнцийн Эзэн Аврахаамын өмнө ийм байдлаар явж байсан учраас тэрбээр Хинаан нутгийг эзэмших бат итгэлтэй болжээ. Тэгвэл энэ түүхийг сонсож байгаа Израйльчууд ч гэсэн өөрсдийн цаг үедээ тэр нутгийг эзэмших бат итгэлтэй болох ёстой юм.

Урьдчилсан дохио болж байгаа нь бүр тод үзүүлсэн өөр нэг хэсэг бол Аврахаамыг Египетээс аврагдан гарч байгаа тухай өгүүлсэн Эхлэлийн 12-ийн 10-аас 20 хүртэлх ишлэл юм. Мөшэх энэ хэсгийг Египет орны талаарх Израйльчуудын үзэл бодолд зааварчилгаа болгох гэж бичсэн байна. Энд Мөшэх тухайн болсон үйл явдлыг бүхэлд нь түүний удирдлагад явж буй Израйльчуудад тохиолдсон явдалтай тун төстэй байдлаар зэрэгцүүлэн бичжээ. Эхлэл 12-р бүлгийн 10-аас 20-д Хинаан нутагт өлсгөлөн гамшиг болсон учраас Аврахаам Египетэд түр суух болсон тухай өгүүлдэг. Түүнийг Египетэд саатаж байх үед Египетийн хаан эхнэр Сарайг нь татвар эмээ болгон ордондоо аваачдаг. Харин Ертөнцийн Эзэн Египетийн хаан болон түүний ордныхонд гай гамшиг илгээж Аврахаамыг авардаг билээ. Тэгээд Египетийн хаан Аврахаамыг нутгаасаа гаргаж явуулдаг. Аврахаам нэлээд их эд хөрөнгөтэй болж Египетийг орхин явдаг.

Энэ түүхийг олон жилийн дараа Израйль үндэстэнд тохиолдсон явдлын урьдчилсан дохио болохоор тун тодорхой бичсэн байна. Израйльчууд яг л Аврахаамтай адил Хинаан нутагт өлсгөлөн гамшиг тохиолдсон учраас Египетэд түр суурьшсан билээ. Тэднийг тэнд мөн л Египетийн хаан барьж саатуулж байсан. Тэд бас Египетийн хааны ордныхонд Ертөнцийн Эзэний илгээсэн өвчин зовлонгийн үр дүнд чөлөөлөгддөг. Египетийн хаан Израйльчуудыг суллан явуулах тушаал гаргадаг. Израйльчууд тэндээс гарахдаа Египетчүүдийн баялгийг цөлмөөд гардаг билээ. Мөшэх энэ баримтыг зориуд оруулж бичсэн. Тиймээс энэ нь түүний уншигчдын амьдралд тохиолдож байгаа явдлыг урьдчилан хэлсэн юм. Үйл явдлыг ингэж урьдчилсан хэлсэн хэсэг Аврахаамын түүхэнд тийм их гардаггүй ч иймэрхүү холбоос хэсэг бусад маягаар орсон байдаг.

Ийнхүү бид Аврахаамын амьдралыг нэг бүрчлэн уншихдаа энэ гурван холбоосыг өөр өөр цаг үед өөр өөр хэлбэрээр орсныг үзлээ. Мөшэх Израйльчуудын үзэж туулж буй бүхний түүхэн нөхцөл байдлыг өгүүлж, даган дууриах эсвэл үгүйсгэн татгалзах үлгэр дууриалыг хэлж, тэдэнд тохиолдож буй олон үйл явдлыг Аврахаамын амьдралд хэрхэн харуулсаныг үзүүлэн Аврахаамын амьдарч байсан “тэр ертөнцийг” анхны уншигчдынхаа “ертөнцтэй” холбож байна.

Ийнхүү бид Аврахаам болон өөрийн уншигч Израйльчуудыг хооронд нь

холбохын тулд Мөшэхийн бичсэн холбоосын төрлийг үзлээ, Тэгэхлээр Аврахаамын амьдралын чухал алхам бүрийг Мөшэх анхныхаа уншигчидтай хэрхэн холбосныг хураангуйлах нь тустай байх болов уу.

ХУРААНГУЙ ДҮН

Аврахаамын амьдралыг таван тэнцвэртэй үе болгож хуваасаныг та нар санаж байгаа байх. Эдгээр үе тус бүрд Мөшэх Аврахаамын амьдралын түүхийг өөрийн анхны уншигчдын нөхцөл байдалтай холбосон байдаг.

Мөшэх эхлээд Аврахаамын уг гарал болон Ертөнцийн Эзэнтэй харилцсан эхний харилцааг өөрийг нь дагаж Египетээс гарсан хүмүүсийн уг гарал ба Ертөнцийн Эзэнтэй анхлан харилцсан харилцаатай холбож өгүүлдэг. Аврахаам болон Израйльчууд бүгд нэг гэр бүлээс гаралтай байв. Аврахаамыг ч, Израйльчуудыг ч хоёуланг нь Ертөнцийн Эзэн Хинаан нутагт суурьшуулахаар дуудсан юм. Ийнхүү Мөшэх түүхэн нөхцөл байдлыг дурдаж, Аврахаамыг үлгэр дууриал болгож байна. Түүгээр ч барахгүй Аврахаамын амьдрал нь анхны уншигч Израйльчуудад тохиолдсон явдлын урьдчилсан дохио болж байгааг харуулсан.

Хоёрдугаарт, Мөшэх Аврахаам бусад хүмүүстэй анх хэрхэн харилцаж байсныг уншигчдынхаа амьдралтай холбон үзүүлсэн. Израйльчууд тухайн үедээ Египетчүүдтэй харилцаж байсан учраас Аврахаам Египетчүүдтэй хэрхэн харилцаж байсныг Мөшэх өгүүлсэн. Израйльчууд Лоотын удам болох Муаб, Аммуно овог аймгийн хүмүүстэй харилцаж байсан учраас Мөшэх Лоотын тухай бичсэн. Мөн тэрбээр дорнын хаад болон Сидом хотыг захирч байсан Хинаан овгийн хааны тухай бичсэн. Учир нь Израйльчууд мөн адил харийн хаадтай учирч, Хинааны хот суурингуудаар дайран өнгөрч байсан билээ.

Гуравдугаарт Мөшэх Ертөнцийн Эзэний гэрээний тухай бичсэн. Учир нь Израйльчууд ч бас Ертөнцийн Эзэнтэй гэрээний харилцаанд орсон юм. Аврахаамын Ертөнцийн Эзэнтэй тогтоосон гэрээ нь Израйльчуудтай тогтоосон Түүний гэрээг олон янзын байдлаар урьдчилан хэлсэн байдаг.

Дөрөвдүгээрт, Мөшэх Аврахаамын бусад хүмүүстэй харилцсан хожмын харилцааны талаар бичсэн. Тэрбээр Сидом, Гомораах хотын иргэд, Лоот болон Пилэшэт хүн Аби-Мэлээхийн тухай бичсэн билээ. Тухайн үед Израйльчууд мөн адил иймэрхүү хүмүүстэй учирч байв. Тэд Хинааны хотуудаар орж, Муаб, Аммуно болон Пилэшэт овог аймгийн хүмүүстэй харилцаж байлаа.

Тавдугаарт, Мөшэх Аврахаамын үр хүүхэд болон нас барсан үйл явдлыг Израйль уншигчдынхаа амьдрал байдалтай холбон бичсэн байна. Тэрбээр Аврахаамын онцгой хүү бөгөөд өв залгамжлагч нь болсон Яйцхаахад гол анхаарлаа хандуулдаг. Яагаад гэвэл түүний уншигчид болох Израйльчууд нь Яйцхаахын удам билээ. Мөн тэрбээр Сараахыг оршуулсан газрыг чухалчлан авч үздэг. Энэ газар нь Израйльчуудад Ертөнцийн Эзэний амласан нутагт байсан юм. Аврахаамын өв залгамжлагч болоогүй бусад хүүхэд, ялангуяа Яйшмагийлд анхаарлаа хандуулдаг. Израйльчууд ч гэсэн тухайн үедээ Яйшмагийл шиг хүмүүсийн асуудлыг шийдэх ёстой байлаа.

Тэгэхлээр Мөшэх Аврахаамын тухай бичихдээ түүний талаар өгүүлсэн түүх болон Израйль уншигчдын нөхцөл байдлыг янз бүрийн байдлаар холбож бичсэн байна. Тэрбээр энэ бүхнийг өөрийг нь дагаж Ертөнцийн Эзэний амласан нутаг руу явж байгаа Израйльчуудад хэрэгтэй чухал удирдамж болохоор бичсэн байна.

Ийнхүү Мөшэх Аврахаамын амьдралыг анхныхаа уншигчид болох Израйльчуудын амьдралтай холбосон гол хэлбэрүүдийг бид харлаа. Харин одоо бид Аврахаамын амьдралыг өгүүлсэн хэсгийн эх утгатай холбоотой өөр нэг чухал асуултанд хариулах хэрэгтэй боллоо. Эдгээр холбоос нь анхны тэр уншигчдад ямар далд санааг өгүүлж байна вэ? Тэд Аврахаамын амьдралын түүхээс юуг сурах ёстой байв?

ДАЛД САНАА

Мэдээж хүмүүс Эхлэл номонд буй Аврахаамын амьдрал шиг нарийн төвөгтэй түүхийг бичихдээ янз бүрийн сонирхол, зорилгод автагдаж байсанд эргэлзэх хэрэггүй. Тэд өөрсдийн бичсэн түүхээ уншигчдад гүнзгий нөлөө үзүүлэхийг хүсэж байсан. Үнэнийг хэлэхэд Аврахаамын амьдралын тухай Мөшэх бичихдаа олон янзын санаа агуулж байсан учир тэр бүгдийг нь тайлж уншаад хэдхэн өгүүлбэрт багтааж бичих боломжгүй билээ. Гэхдээ Аврахаамын тухай өгүүлсэн түүний түүхээс анхны уншигчдынхаа олж мэдээсэй гэж Мөшэхийн найдаж байсан гол санаануудыг хураангуйлах боломжтой юм.

Бид Аврахаамын амьдралаас урган гарах далд санаануудыг гурван үе шаттай судлана. Нэгдүгээрт, бид эдгээр түүхийн анхны уншигчдад ямар үндсэн нөлөө үзүүлэх зорилготой бичигдсэнийг тодорхойлох болно. Хоёрдугаарт, бид эдгээр түүхийн үзүүлэх нөлөө хэрхэн ил болж, улмаар Аврахаамын амьдралын дөрвөн гол сэдвийг хэрхэн хөндөж байгааг үзнэ. Тэгээд гуравдугаарт бид Аврахаамын амьдралыг таван үе шат болгон Мөшэхийн бичсэн хэсэг бүрийн анхны санааг хураангуйлан бичих болно. За одоо эхлээд эдгээр түүх ямар үндсэн санаа илэрхийлж байгааг үзэцгээе.

ҮНДСЭН НӨЛӨӨ

Ерөнхийдөө энэ нь Аврахаамын тухай түүхийн зорилгыг хураангуйлахад тус болно: Мөшэх Израйльчуудад Египет орныг яагаад орхин гарч байгааг, хэрхэн тэндээс явж Ертөнцийн Эзэний амласан нутгийг эзлэн авахыг заахын тулд Аврахаамын тухай бичсэн юм. Өөрөр хэлбэл, Мөшэхийг дагаж буй Израйльчууд Аврахаамаас амьдралынхаа түүхэн нөхцөл байдлыг харж, түүний түүхээс даган дууриах эсвэл үгүйсгэн татгалзах үлгэр жишээг олж, түүний амьдрал өөрсдийнх нь амьдралын урьдчилсан дохио болж байгааг гярхай ажигласнаар өөрсдөд нь зориулсан Ертөнцийн Эзэний зорилгод хэрхэн хүрэх арга замаа ойлгож чадах байв.

Бид Библид буй үгэнд, түүгээр ч барахгүй Есүсийн өөрийнх хэлсэн үгэнд

үндэслээд Эхлэл номыг Мөшэхийн амьдарч байх үед бичсэн гэдэгт баттай найдаж болох ч бидэнд буй энэ номыг Мөшэх яг хэзээ бичиж дууссаныг баттай хэлж чадахгүй гэдгээ анхаарах хэрэгтэй байх. Гэсэн хэдий ч Аврахаамын түүхийг бичиж байхдаа Мөшэхийн санаа тавьж байсан гол зүйл нь аль аль үеийнхэнд нь тун адил төстэй байсан гэж итгэлтэй хэлж болно. Тэрбээр Израйльчуудын зүрх сэтгэлийг Египетээс холдуулж Ертөнцийн Эзэний амласан нутаг руу хандуулахын тулд Аврахаамын тухай түүхийг бичсэн юм.

Анхны уншигчдад зориулж хэлж буй энэ ерөнхий санааг бас нэг их дөвийлгөн үзэж болохгүй. Мөшэх өөрийг нь дагаж буй Израйль үндэснийг хэзээ ч Египет рүү буцахгүй байж, Хинаан нутгийг эзлэн авахад нь урамшуулан зоригжуулахын тулд л үүнийг бичсэн юм. Энэ өргөн хүрээг хамарсан далд санаа нь бидэнд Аврахаамын амьдралыг өнөө үед хэрэглэхэд удирдамж болдог. Бид Христэд итгэгчийнхээ хувьд бүгд аялалд яваа улсууд билээ. Үнэндээ бидний энэ аялал бол Мөшэхийн үед Израйльчуудын эхэлсэн аялалын төгсгөл юм. Бид мөнхийн улсад орохоор аялаж байгаа билээ. Тиймээс бид Аврахаамын тухай түүхийг амьдралдаа зөв хэрэгжүүлэхийн тулд үүнийг Хинаан нутаг руу явж буй анхны уншигчдад хэрхэн зааварчилж байгаад гол анхаарлаа хандуулах ёстой.

Энэ гол анхаарлаа хандуулсан ерөнхий санааг ойлгохын тулд бид Эхлэл номонд аль хэдийн тодорхойлсон дөрвөн сэдэвтээ эргэн орж байгаад Мөшэхийн зорилгыг нарийвчлан судлах хэрэгтэй.

ГОЛ СЭДВҮҮД

Хичээлийнхээ эхэнд бид Эхлэлийн 12-р бүлгийн 1-3-д Израйлийн алдарт өвгийн амьдралын энэ хэсэгтэй уялдаатай дөрвөөс доошгүй сэдвийг танилцуулсан гэж хэлж байсныг та нар санаж байгаа байх. Энэ дөрвөн сэдэв нь бичсэн түүхээрээ Мөшэхийн үзүүлэхийг хүссэн гол нөлөөг илэрхийлж чадна. Эхлээд, тэрбээр Аврахаамд үзүүлсэн Ертөнцийн Эзэний хайр өршөөлийг чухалчилсан. Хоёрдугаарт, Аврахаамын үнэнч байдалд гол анхаарлаа хандуулсан. Гуравдугаарт, тэрбээр Аврахаамд өгсөн сайн сайхан зүйлсийн тухай бичсэн. Харин дөрөвдүгээрт Аврахаамаар дамжин ирэх сайн сайхна зүйлсийг онцлон үзсэн байна. Аврахаамын тухай бичих болсон Мөшэхийн анхны зорилгыг энэ дөрвөн санаатай холбож бодох нь тустай байх болно.

Ертөнцийн Эзэний хайр өршөөл

Ертөнцийн Эзэн Аврахаамд өршөөл энэрлээ хэрхэн харуулсаныг Мөшэх эхлээд бичжээ. Үүнийг өргөн утгаар нь авч үзвэл Ертөнцийн Эзэн Аврахаамтай анх харилцаа тогтоохдоо ч, мөн насан туршид нь өдөр бүр хайр өршөөлөө үзүүлж байсан гэдгийг бид аль хэдийн үзсэн. Түүний хайр өршөөлийн тухай энэ санаа нь Мөшэхийн үед амьдарч буй Израйльчуудад ч гэсэн Ертөнцийн Эзэн агуу их өршөөл энэрлээ үзүүлсэн гэдгийг сануулах зорилготой байлаа. Эхлээд Ертөнцийн Эзэн тэднийг

Египетээс гарган Синайн ууланд авчирч хайр өршөөлөө үзүүлсэн байлаа. Мөн Тэрбээр тэднийг Хинаан нутгийг эзлэн авахад бэлтгэж байхдаа өдөр бүр өршөөл энэрлээ харуулж байв.

Синай уулан дээр Ертөнцийн Эзэний хэлсэн нэгэн алдартай үг байдаг. “Египетээс гарсан нь” номын 19-р бүлгийн 4-т Ертөнцийн Эзэний хайр өршөөлийг:

Би Египетчүүдэд хэрхэн хандаж, та нарыг бүргэдийн жигүүр дээр тээн яаж Өөртөө авчирсныг та нар харсан (Египетээс гарсан нь 19:4).

Харамсалтай нь Мөшэхийн удирдаж байсан Израйльчууд Ертөнцийн Эзэнээс ямар их өршөөл энэрэл хүртсэнээ мартсан байлаа. Тэд аян замаа эхлээд удаагүй байхдаа л Ертөнцийн Эзэн Мөшэх хоёр тэднийг Египет дэхь тав тухтай амьдралаас нь салгаж хууран мэхэлсэн хэмээн гомдоллох болов. Цөлд амьдарч байхдаа хоол хүнс, унд усны талаар гомдоллож байлаа. Ертөнцийн Эзэн тэднийг Амласан нутгийг эзлэн авахаар нэвтрэн орох талаар хэтэрхий ихийг шаардаж байна гэж тэд бодож байв. Тиймээс Мөшэх анхны уншигчиддаа Ертөнцийн Эзэн хэрхэн тэднийг ивээснийг, өршөөл энэрлээ хэрхэн харуулсаныг дахин дахин сануулахын тулд Ертөнцийн Эзэн Аврахаамд хайр өршөөлөө хэрхэн үзүүлж байсныг онцлон тэмдэглэж байлаа.

Аврахаамын үнэнч байдал

Хоёрдугаарт, Ертөнцийн Эзэн өгсөн тушаалаа дагуулахын тулд Аврахаамыг хариуцлагатай болгож байсан олон зүйлд Мөшэх Израйльчуудын анхаарлыг бас хандуулан Аврахаамын үнэнч байдлыг онцолж байсныг бид үзсэн. Ертөнцийн Эзэн Өөрийнх нь тушаалыг үнэнчээр дагахыг Израйлийн энэ алдарт өвгөөс хүсэн хүлээж байсан гэдгийг Мөшэх дахин дахин онцолж байлаа. Энэ бүхэн өөрийг нь дагаж буй Израйльчуудад хамаатай байсан тул тэрбээр үүнийг чухалчлан үзжээ. Үнэнч байх энэ шаардлагыг Мөшэхийн үеийн Израйльчуудад ч гэсэн тавьсан юм. Ертөнцийн Эзэн Синай уулан дээр Израйльчуудад хандсан хэлсэн үгийг “Египетээс гарсан нь” номын 19-р бүлгийн 4, 5-р ишлэлээс үргэлжлүүлэн үзэцгээе. Тэнд:

Би Египетчүүдэд хэрхэн хандаж, та нарыг бүргэдийн жигүүр дээр тээн яаж Өөртөө авчирсныг та нар харсан. Хэрэв та нар намайг бүрэн дагаж, гэрээг минь биелүүлбэл бүх үндэстэний доторхи миний үнэт өмч болно (Египетээс гарсан нь 19:4-5).

Израйльчуудын үнэнч байдлаас тэдэнд өгсөн Ертөнцийн Эзэний ивээл үнэт өмч болох эсэх нь шалтгаалж байгааг энэ ишлэлээс мэдэж болно. Хэдийгээр Ертөнцийн Эзэн энэ үндэстэнд өршөөл энэрлээ ихээр харуулж байсан ч Түүний тушаалд тэд хэрхэн хандаж байгаагаас тухайн үеийн хүн бүрийн байр суурь шалтгаалж байлаа.

Тэгэхлээр Ертөнцийн Эзэнээс Аврахаамд хүлээлгэсэн гол үүрэг бол Хинаан нутаг руу явах явдал байсан гэдгийг бид үзлээ. Өөрийг нь дагаж буй Израйльчууд Хинаан нутгийг чиглэсэн замаасаа хазайхгүй байхыг Мөшэх бас хүсэж байсан тул энэ үүрэг хариуцлагыг чухалчлан үзсэн байна. Мэдээж, Мөшэх Аврахаамын бусад

үүрэг хариуцлагын тухай бичсэн. Тэрбээр үүнийг тухайн үед өөрийг нь дагаж явсан Израйльчуудад тэдний үүрэг хариуцлагын тухай заахын тулд ингэсэн юм. Аврахаамаас шаардаж байсан үнэнч байдлын олон шаардлага нь Мөшэхийн анхны уншигчдад Ертөнцийн Эзэний тушаалыг үнэнч дуулгавартай дагах талаар илэн далангүй хэлсэн байдаг.

Аврахаамд өгсөн сайн сайхан зүйлс

Гуравдугаарт, Аврахаамд амласан Ертөнцийн Эзэний сайн сайхан зүйлсийн тухай сэдэв нь ямар чухал болох талаар бид үзсэн. Мөшэх энэ номондоо Аврахаам болон түүний үр удамд Ертөнцийн Эзэний амласан агуу үндэстэн болж, хөгжил дэвшилд хүрч, алдар нэрийг олно гэсэн амлалтанд гол анхаарлаа хандуулсан байдаг. Аврахаам амьд сэрүүн байхдаа нилээд хэдэн тохиолдолд энэ бүх ивээлийг бага сага ч болтугай хүртэж магнай нь тэнийж байсныг бид үзсэн. Мөн нэлээд хэдэн тохиолдолд Аврахаамын тухай түүх нь энэ бүх ивээлийг дараа дараагийн үед бүрэн хүртэх болно гэсэн санааг онцолсон байдаг. Тиймээс Мөшэх тухайн үедээ Аврахаамын хүртсэн сайн сайхан зүйлс дээр анхаарлаа хандуулсан байна. Учир нь энэ бүх сайн сайхан зүйл нь түүний удирдаж буй Аврахаамын удам угсаа болсон Израйлийн ард түмэнд бас хамаатай байсан юм. Израйлийн ард түмэнд ч гэсэн Ертөнцийн Эзэн агуу их ивээлийг амласан билээ. Тэд Ертөнцийн Эзэний амласан нутагт орсон цагтаа л агуу үндэстэн болж, асар их хөгжин цэцэглэж, алдар хүндийг дээдийг хүртэж байлаа.

Үнэндээ бол Эхлэл номыг бичигдэж байх тэр үед Израйльчууд Аврахаамтай адил энэ бүх ивээлийг эхнээс нь хүртэж баяр хөөрийг эдлэж байв. Тэд өөрсдийнхөө үед эдгээр амлалтын зарим нэг нь аль хэдийн биелэж эхэлснийг харсан. Гэсэн хэдий ч тэднийг Амлалтын нутагт орсоны дараа ирээдүйд биелэх ивээлүүд ч үүнд багтаж байсан билээ. Израйльчуудын ирээдүйд хүртэх энэ бүх ивээлийн тухай Ертөнцийн Эзэн Синай уулан дээр ингэж хэлсэн байдаг. “Египетээс гарсан нь” номын 19-р бүлгийн 6-д:

Миний хувьд та нар Надад үйлчлэх хүмүүсийн хаант улс, ариун үндэстэн болно (Египетээс гарсан нь 19:6).

Мөшэх тухайн үеийнхээ Израйльчуудын итгэл найдварыг өргөхийн тулд Аврахаамд амласан Ертөнцийн Эзэний ивээлүүдийг бичсэн юм. Тэд энэ тухай уншиж байхдаа Ертөнцийн Эзэн өөрсдөд нь ямар агуу ивээлүүдийг хадгалж байгааг тодорхой ойлгож чадах байлаа.

Аврахаамаар дамжин ирэх сайн сайхан зүйлс

Дөрөвдүгээрт бид Израйлийн энэ алдарт өвгөөр дамжуулан Ертөнцийн

Эзэний ивээл бүх хүн төрөлхтөнд хүрнэ гэдгийг Аврахаамын тухай түүхээс бас харсан. Аврахаамаар дамжих сайн сайхан зүйлс нь зүгээр л хүрээд ирэхгүй гэдгийг та нар санаж байгаа байх. Ертөнцийн Эзэн энэ бүгдийг Аврахаамд өгөхдөө түүний анд нөхдийг ивээж, өстөн дайснуудыг нь хараах замаар түүнд ололт амжилтыг өгнө гэдгийг бид Эхлэлийн 12-р бүлгийн 3-аас үзсэн. Аврахаамыг амьд мэнд байх үед түүнийг янз бүрийн улс үндэстнийг төлөөлсөн өөр өөр хүмүүстэй харилцаж байхад нь Ертөнцийн Эзэн эдгээр ивээлээ амсуулж байлаа. Мөшэх Аврахаамын тухай түүхийнхээ хэд хэдэн хэсэгт эдгээр ивээлийн ихэнх нь ирээдүйд бүрэн биелэнэ гэж хэлсэн байдаг.

Тухайн үед өөрийг нь дагаж байсан Израйлийн ард түмэнд маш их хамаатай байсан учраас Мөшэх энэ санааг чухалчлан үзсэн байна. Ертөнцийн Эзэн Израйлийн ард түмний анд нөхдийг ивээж, өстөн дайснуудыг нь хараах учраас тэднийг бусад үндэстэнд сайн сайхныг өгөх ивээл болох амжилтын баталгааг Тэрбээр өгсөн юм. Тэд ч бас тухайн үедээ янз бүрийн хүмүүстэй харилцаж байхдаа энэ амлалт хэрэгжиж байгааг үзэж мэдэрсэн билээ. Ертөнцийн Эзэн анд нөхдийг нь ивээж, өстөн дайснуудыг нь харааж байгааг тэд аль хэдийн нэлээд хэдэн үйл явдлаас харсан байна. Үүнээс гадна Израйльчуудыг Ертөнцийн Эзэний амласан нутагт ороод Түүний хаант улсыг энэ дэлхийн өнцөг булан бүрт хүргэх үйл хэрэг ирээдүйд биелэх болно гэдэгт тэдний анхаарлыг хандуулах талаар Мөшэх бас анхаарсан байдаг. Дөнгөж саяхан бид “Египетээс гарсан нь” номын 19-ийн 6-д Ертөнцийн Эзэн Израйльчуудад хандан:

Миний хувьд та нар Надад үйлчлэх хүмүүсийн хаант улс, ариун үндэстэн болно (Египетээс гарсан нь 19:6).

Ирээдүйд Израйль үндэстэн Ертөнцийн Эзэнд үйлчлэх хүмүүсийн хаант улс болно гэдэг энэ хэтийн дүр зураг нь зөвхөн тэд л Түүний ариун хүмүүс болох онцгой эрхтэй гэсэн санааг хэлээгүй. Энэ нь Израйлийн үр сад дэлхийн даяар Ертөнцийн Эзэний зорилгод үйлчилнэ гэсэн санааг бас хэлсэн юм. Нэг талаар Мөшэх Израйльчуудыг Ертөнцийн Эзэний амласан нутаг руу хөдлөхийг уриалан дэмжиж байсан. Бас нөгөө талаар Ертөнцийн Эзэн хаант улсаа тэлж, ивээлээ хайраа бүх дэлхийд хүргэхийн тулд Израйльчуудыг хэрхэн ашиглах тухай дүр зургийг тэдний санаанд оруулах зорилгоор Аврахаамын түүхийг зохиомжилсон байна.

Ийнхүү бид Аврахаамын амьдралын тухай өгүүлсэн хэсэгт гарах 4 гол сэдэв Мөшэхийн анхны уншигчдад ямар далд санаа хэлж байгааг үзлээ. Харин одоо бүгдээрээ Эхлэл номонд өгүүлсэн Аврахаамын амьдралын түүхийн голлох үе шат бүрийг судалж, энэ бүхэн Мөшэхийн анхны уншигчдад ямар нөлөө үзүүлсэнийг хураангуйлан үзэцгээе.

ТАВАН ҮЕ ШАТ

Аврахаамын амьдралын тухай түүхийг 5 гол үе болгож хуваадгийг та нар санаж байгаа байх. Нэгдүгээрт, Аврахаамын уг гарал ба Ертөнцийн Эзэнтэй

харилцсан эхний харилцааг Эхлэлийн 11-р бүлгийн 10-аас 12-р бүлгийн 9-д бичсэн. Хоёрдугаарт, Аврахаамын бусад хүмүүсийн төлөөлөлтэй харилцсан эхний харилцааг 12-р бүлгийн 10-аас 14-р бүлгийн 24-д өгүүлдэг. Гуравдугаарт, Аврахаамын Ертөнцийн Эзэнтэй тогтоосон гэрээний тухай 15-р бүлгийн 1-ээс 17-р бүлгийн 27-д гардаг. Дөрөвдүгээрт, Аврахаамын бусад хүмүүсийн төлөөлөлтэй харилцсан хожмын харилцааг 18-р бүлгийн 1-ээс 21-р бүлгийн 34-т өгүүлдэг. Харин тавдугаарт, Аврахаамын үр хүүхдүүд ба түүний нас барсан тухай 22-р бүлгийн 1-ээс 25-р бүлгийн 18-д гардаг.

Эдгээр үе бүр нь дотроо хэд хэдэн жижиг хэсэг буюу үйл явдалд хуваагддаг. Бид анхны уншигчиддаа Мөшэхийн хандан бичсэн эдгээр хэсгийн агуулга болон ямар гол далд санааг хэлж байгааг хураангуйлан үзэх болно.

Уг гарал ба эхний харилцаа

Аврахаамын уг гарал болон эхний харилцааг өгүүлсэн хэсэгт түүний гэр бүл болон Ертөнцийн Эзэний ажилд дуудагдсан цаг үеийн талаар нэлээд хэдэн чухал зүйлийг мэдээлдэг. Ерөнхийдөө бол Мөшэх энэ эхний үеийг анхны уншигч Израйльчуудыг Аврахаамын амьдралд тохиолдсон үйл явдлуудаас өөрсдийнхөө уг гарал болон Ертөнцийн Эзэнээс хүлээн авсан дуудагаа хэрхэн мэдэж авч болохыг харуулах зорилготой бичсэн байна.

Энэ эхний үе нь гурван үйл явдал буюу хэсэг болж хуваагддаг. 11-р бүлгийн 10-аас 26-р ишлэлд гарах Аврахаамын амьдралыг өгүүлсэн хэсэг нь Ертөнцийн Эзэний таалалд нийцсэн түүний угсаа гарлыг дурдсан угийн бичгээр эхэлдэг. Ертөнцийн Эзэний онцгойлон сонгосон хүмүүс гэдэг тусгай байр суурийг Түүний өмнө эдлэж байсан Шээмийн гэр бүлийн ноён оргил болсон хүн бол Аврахаам гэдгийг эдгээр ишлэл тогтоодог. Аврахаамын гэр бүлийн удам угсаа учраас тэд ч бас Ертөнцийн Эзэний онцгойлон сонгосон хүмүүс тул Түүний өмнө ийм байр суурьтай байдаг гэдгийг энэ угийн бичиг нь Мөшэхийн анхны уншигчид болох Израйльчуудад сануулах ёстой байлаа.

Аврахаамын уг гарал ба Ертөнцийн Эзэнтэй харилцсан анхны харилцаа гэсэн энэ үеийн хоёрдахь хэсгийг хамарсан 11-р бүлгийн 27-оос 32-д өөр нэг угийн бичиг гардаг. Товчхондоо энэ хэсэг нь Тираах бол бурхан шүтээн шүтэгч бөгөөд Хинаан нутаг руу явах гэж гараад бүтэлгүйсэн хүн гэдгийг дүрслэн бичсэн. Аврахаамын нөхцөл байдал нь өөрсдийнхтэй нь адил төстэй байгааг Мөшэхийн анхны уншигчид тун амархан харж болохоор байлаа. Тэдний эцэг эх нь бурхан шүтээн шүтсэнээсээ болоод Хинаан нутагт хүрч чадахгүй бүтэлгүйтсэн билээ. Тиймээс Аврахаам эцгийнхээ бүтэлгүй явдлыг давтахаас зайлсхийсэн шиг Мөшэхийг дагаж явсан Израйльчууд ч бас бурхан шүтээн шүтсэнээсээ болоод Хинаан нутагт хүрч чадахгүй бүтэлгүйцсэн эцэг эхийнхээ алдааг давтахаас зайлсхийж болох байв.

Аврахаамын уг гарал болон эхний харилцааг өгүүлсэн энэ түүх нь цаашаагаа түүний Хинаан руу нүүсэн аялалаар үргэлжилдэг бөгөөд энэ тухай 12-р бүлгийн 1-ээс 9-д өгүүлдэг. Ертөнцийн Эзэн Аврахаамыг Хинаан нутагт оч гэж дуудсан. Аврахаам үй олон бэрхшээл саадыг үл хайхран Ертөнцийн Эзэний дуудлагыг

дагасан билээ. Яг үүнтэй адил Ертөнцийн Эзэн Мөшэхийн анхны уншигчдыг Хинаан нутаг оч гэж дуудсан. Тэд ч бас үй олон бэрхшээл саадыг үл хайхран энэ тушаалыг дагах ёстой байв. Тиймээс Аврахаамын Хинаан нутаг руу нүүсэн түүх нь Мөшэхийн үеийн Израйльчуудыг Аврахаамын мөрийг мөшгин түүнтэй адил Хинаан нутаг руу нүүдэллэн очих хэрэгтэй гэдэг тийм нэг далд санааг хамгийн түрүүнд өгүүлж байна.

Эхний үед багтсан энэ гурван хэсгээр Мөшэх анхны уншигчиддаа Аврахаамын амьдралыг танилцуулж, улмаар Ертөнцийн Эзэнд үйлчилж байхад нь учрах саад бэрхшээлийг даван туулах удирдамж болгосон байна.

Бусад хүмүүстэй харилцсан эхний харилцаа

Эхлэл номонд дурдсан Аврахаамын амьдралын тухай баримтын хоёрдахь үе нь түүний бусад хүмүүстэй харилцсан эхний харилцааг голлон анхаарсан байдаг. Эдгээр бүлэг нь Израйлийн алдарт өвгийг бусад хүмүүстэй янз бүрийн байдлаар харилцаж байгааг нь анхны Израйль уншигчдад бусад хүмүүстэй хэрхэн харилцах заавар болгохоор дүрслэн үзүүлжээ.

Хоёрдахь үеийн эхний хэсэгт Мөшэх Аврахаамын Египетээс аврагдан гарсан үйл явдлыг Эхлэлийн 12-р бүлгийн 10-аас 20-д бичсэн байна. Өлсгөлөн гамшиг тохиолдсон учраас Аврахаам Египетэд түр оршин сууж байсныг, Ертөнцийн Эзэн Египетийн хааны гэр бүлд өвчин илгээж түүнийг Египетчүүдийн дарлалаас чөлөөлсөн гэдгийг та нар санаж байгаа байх. Ертөнцийн Эзэний оролцсон агуу чөлөөлөлтийн үр дүнд Аврахаам их эд баялагтай болоод Египет орныг орхин гардаг. Египет бол түүний эх орон биш гэдгийг Аврахаам сайтар ойлгож авсан байна.

Тэдний амьдралын олон үйл явдал Аврахаамын тухай түүхийн олон хэсгийн тусгал болж байгааг Мөшэхийн анхны Израйль уншигчид харж чадсан. Тэд бас өлсгөлөнгийн гамшгаас болж Египет оронд ирсэн. Ертөнцийн Эзэн Египетчүүдэд өвчин илгээсэн учраас тэд бас аврагдсан. Тэд Египетчүүдээс маш их эд баялаг аваад тэр орныг оршин гардаг билээ. Харамсалтай нь Израйльчууд аян замдаа олон саад бэрхшээлтэй тулгарахад тэдний зарим нь Египетэд байсан амьдралаа төгс төгөлдөр байсан мэтээр үзэж тийшээ буцаж очихыг хүсэх болсон байна. Тиймээс энэ хэсэг нь Мөшэхийн анхны уншигчдад Египет бол тэдний гэр орон биш гэдгийг тодорхой харуулах ёстой байсан. Тэд Ертөнцийн Эзэн өршөөл энэрлээ харуулж өөрсдийг нь чөлөөлсөн гэдгийг, Египет орон Египетчүүд ард хол хоцорсон гэдгийг эргэн санах хэрэгтэй байв.

Бусад хүмүүстэй харилцсан Аврахаамын эхний харилцааны хоёрдахь хэсэгт түүний Лооттой зөрчилдсөн түүх ордог бөгөөд энэ тухай 13-р бүлгийн 1-18-д өгүүлдэг. Энэ бол Аврахаам болон Лоотын зарц нар хонин сүргийнхээ бэлчээр уснаас болж хоорондоо хэрэлдэн маргалдаж байгааг үзүүлсэн, хүмүүсийн сайн мэдэх хэсэг билээ. Уг зөрчилдөөний үеэр Аврахаам Лоотод сайхан сэтгэлээр хандаж түүнийг сонгосон газартаа амар тайван амьдрахыг зөвшөөрдөг. Энэ түүх ямар утгатай болохыг Эхлэл номын анхны уншигчдын хувьд ойлгоход төдийлөн хэцүү байсангүй. “Египетээс гарсан нь” номын 2-р бүлэгт бичсэнээр бол тэднийг Ертөнцийн Эзэний амласан нутаг руу явж байхад Лоотын удамд сайхан сэтгэлээр

хандаж өвөг дээдсийнхээ амьдарч байсан нутаг амар тайван амьдрахыг нь зөвшөөр хэмээн Мөшэх Израйльчуудад тушаасан байдаг. Үнэндээ бол, Аврахаам Лоотод сайхан сэтгэлээр хандсан нь Израйльчуудыг тухайн үед амьдарч байсан Муаб овгийн хүмүүст хэрхэн хандахыг харуулсан хэрэг юм.

За харин бусад хүмүүстэй харилцсан Аврахаамын эхний харилцааны гуравдахь хэсэг нь Аврахаам Лоотыг хэрхэн аварсан тухай өгүүлдэг бөгөөд энэ тухай 14-р бүлгийн 1-ээс 24-д гардаг. Энэ төвөгтэй түүхэнд Аврахаам алс холоос ирсэн харгис хэрцгий хаадыг хэрхэн ялсан, мөн эдний гараас Лоотыг хэрхэн аварч түүнд дахин сайхан сэтгэлээр хандаж байгааг үзүүлдэг. Тэгээд ч энэ түүх Мөшэхийн дагаж яваа Израйльчуудад илүү тодорхой хэлсэн байдаг билээ. Израйльчууд Лоотын удам угсаа болох Муаб болон Аммуно овог аймгуудын нутгаар дайран өнгөрөхдөө Имөөр овгийн Сихон, Башаан овгийн хаан Ог зэрэг харгис хэрцгий хаадыг ялан дийлдэг. Эд хоёулаа Муаб болон Аммуно овгийнхоныг дарлан зовоож байв. Израйльчууд Муаб, Аммуно овгийнхоныг аварсанаараа Аврахаамын үлгэр жишээг дагасан юм.

Ийнхүү Аврахаамын амьдралын үе бүрд тэрбээр тухайн үеийн Израйльчуудын даган дууриах үлгэр жишээг танилцуулсан юм.

Ертөнцийн Эзэнтэй тогтоосон гэрээ

Одоо бүгдээрээ Аврахаамын амьдралын гуравдахь үеийг үзнэ. Энэ бол Ертөнцийн Эзэнтэй тогтоосон гэрээ бөгөөд 15-р бүлгийн 1-ээс 17-р бүлгийн 27-д гардаг. Ерөнхийдөө энэ үе нь Израйльчуудын Ертөнцийн Эзэнтэй тогтоосон гэрээний харилцааны онцлог шинжийг дэлгэн харуулахын тулд Аврахаамын Түүнтэй байгуулсан гэрээнд голлон анхаарсан байдаг. Эдгээр бүлгийг мөн адил 3 гол хэсэгт хувааж болно.

15-р бүлгийн 1-ээс 21-ийг хамарсан эхний хэсэг нь Аврахаамтай тогтоосон Ертөнцийн Эзэний гэрээний амлалтууд дээр ихэвчлэн төвлөрдөг. Энэ бол Ертөнцийн Эзэн Аврахаамтай гэрээний харилцаанд орж байгаа үеийг өгүүлсэн алдартай бүлэг юм. Ертөнцийн Эзэн Аврахаамд үр хүүхэд, газар нутаг өгөхөөр амласан. Ялангуяа Ертөнцийн Эзэн Аврахаамыг үй олон үр удамтай болгож, улмаар тэднийг хэсэг хугацаагаар харийн нутагт хатуу ширүүн зовлон зүдгүүрийг туулсаны дараа Өөрийн амласан нутагт аваачихаа тэдэнд амладаг. Ертөнцийн Эзэн Мөшэхээр дамжуулан Израйльчуудтай үүнтэй төстэй гэрээ байгуулсан гэдгийг энэ хэсэг тэдэнд сануулах зорилготой байв. Түүгээр ч барахгүй энэ хэсэг Ертөнцийн Эзэний Аврахаамд өгсөн амлалт биелэж эхэлснийг тэд өөрсдөө үзэж мэдэрч байгааг харуулсан. Израйльчууд бол Аврахаамд өгөхөөр Ертөнцийн Эзэний амласан үр хүүхдүүд бөгөөд тэд өвөг дээдэст нь өгөхөөр Түүний амласан тэр л нутаг руу буцаж байгаа юм. Энэ бүхэнд эргэлзэнэ гэдэг нь Ертөнцийн Эзэн өршөөл энэрлээрээ Аврахаамтай байгуулж, Мөшэхтэй дахин баталгаажуулсан гэрээний амлалтуудад эргэлзэж байгаатай адил хэрэг болох ажээ.

Аврахаамын Ертөнцийн Эзэнтэй тогтоосон гэрээ гэсэн энэ үеийн хоёрдахь хэсэгт түүний Хагаартай бүтэлгүйтсэн амьдралыг өгүүлдэг. Энэ тухай 16-р бүлгийн 1-ээс 16-д гарна. Энэ гунигтай түүх нь бидэнд Аврахаам Сараах хоёр хэрхэн

Ертөнцийн Эзэний гэрээний амлалтанд эргэлзэж Сараахын Египет зарц бүсгүй Хагаараас хүүхэдтэй болох гэж оролдсоныг бидэнд сануулдаг. Аврахаам Хагаар хоёр Ертөнцийн Эзэний гэрээний амлалтанд найдаж чадаагүй. Ертөнцийн Эзэн Яйшмагийлийг Аврахаамын жинхэнэ хүүхэд гэж хүлээн зөвшөөрөхгүй гэдгээ харуулж тэдний нөөц төлөвлөгөөг үгүйсгэдэг билээ. Мөшэхийн анхны уншигчид ч гэсэн Ертөнцийн Эзэний гэрээний амлалтанд дахин дахин эргэлзэж Египетийн тав тухыг эрэлхийлж байв. Ийнхүү Аврахаамын амьдралын энэ түүх нь Ертөнцийн Эзэн Аврахаамын өөр төлөвлөгөөг хүлээн аваагүйтай адил Өөрийнх нь төлөвлөгөөний оронд Израйльчуудын сэдсэн төлөвлөгөөг хүлээн авахгүй гэдгийг тэдэнд заасан байна.

Аврахаамын Ертөнцийн Эзэнтэй тогтоосон гэрээний гуравдахь хэсэг нь уг гэрээний нөхцөл дээр голлон анхаарсан байдаг. Энэ тухай 17-р бүлгийн 1-ээс 27-д гарна. Энэ хэсэгт Өөрийнх нь төлөвлөгөөг дагаагүй бүтэлгүйтсэн Аврахаамтай Ертөнцийн Эзэн тулгарч байгаа тухай өгүүлнэ. Мөнхийн Эзэн тэдэнтэй гэрээ байгуулсаны шинж тэмдэг болгож Аврахаам болон түүний хүүхдүүдэд хөвч хөндөх ёслол үйлдэж байхыг тогтоож өгдөг. Тэрбээр үүгээр дамжуулан уг гэрээнд үнэнч байх шаардлагатай гэдгийг дахин баталгаажуулсан. Ертөнцийн Эзэн энэ шинж тэмдгээр дамжуулан Түүний гэрээний харилцаа нь үнэнч байх хариуцлагыг шаарддаг гэдгийг Аврахаамд сануулсан юм. Энэ үнэнч байдал нь асар их ивээлд хөтлөн аваачих ажээ. Мөшэх өөрийн үеийн Израйльчуудын энэ гэрээнд үнэнч байж чадаагүй бүтэлгүйтсэн явдалтай нүүр тулгарахдаа Аврахаамын гэрээний энэ талыг тоочиж, улмаар тэднийг Ертөнцийн Эзэний гэрээнд үнэнч байх шаардлагатай болохыг дахин нотолсон юм. Израйльчууд Ертөнцийн Эзэнтэй тогтоосон гэрээндээ үнэнч байсан цагтаа л Түүний агуу их ивээлийг хүртэнэ гэж баттай найдаж болох байлаа.

Тэгэхлээр Аврахаамын амьдралын гол зүйл болох Ертөнцийн Эзэнтэй байгуулсан гэрээ нь цаашлаад Израйльчуудын анхаарлыг Түүний гайхалтай амлалт руу хандуулав. Гэхдээ энэ нь бас Мөшэхийн уншигчдыг Ертөнцийн Эзэнтэй байгуулсан гэрээнд үнэнч байгаагаа олон түмэнд харуулах үүрэг хүлээсэн гэдгийг хүчээр сануулж байна.

Бусад хүмүүстэй харилцсан хожмын харилцаа

Одоо бүгдээрээ 18-р бүлгийн 1-ээс 21-р бүлгийн 34-д гарах Аврахаамын амьдралын дөрөвдэхь үе буюу “Бусад хүмүүстэй харилцсан хожмын харилцааг”-г үзэцгээе. Эдгээр бүлэгт Мөшэхийн үед амьдарч байсан хүмүүстэй холбоотой янз бүрийн улсуудтай Аврахаам учирч байгаа тухай өгүүлдэг. Аврахаам Сидом, Гомораах хотын Хинаан оршин суугчид болон Лоот, Аби-Мэлээх, Яйшмагийл нартай харилцдаг. Товчхондоо бол эдгээр хүмүүстэй Аврахаамын харилцсан харилцаа нь Израйльчуудад тухайн үеийнхээ Хинаачууд, Муаб, Аммун овгийнхон болон Пилэшэт аймгийнхан, Яйшмагийлийн удамтай хэрхэн харилцахыг зааж өгсөн юм.

Аврахаамын амьдралын энэ үеийн эхний түүх нь Сидом, Гомораах хотын

тухай өгүүлдэг бөгөөд 18-р бүлгийн 1-ээс 19-р бүлгийн 38 хүртэлх хэсгийг хамардаг. Олонд алдартай энэ хүүрнэл түүх нь ёрын мууг үйлддэг Хинааны хотуудын эсрэг Ертөнцийн Эзэний оноосон шийтгэлийн аюулыг өгүүлдэг билээ. Эдгээр хотод байгаа гэмгүй хүмүүс болон сүйрэл, мөн Лоотыг аврах талаар Аврахаам яаж санаа тавьж байгаа нь гарна. Энэ бүх үйл явдал нь Мөшэхийн анхны уншигчдад тулгарсан нөхцөл байдлыг шууд хэлсэн байдаг. Энэ түүх нь Хинаанчуудад ирэх Ертөнцийн Эзэний аюул, Хинаанчуудын дунд гэм буруугүй хүн байгаа эсэхэд (Тэдэнтэй тааралдсан Ерийхүү хотын Рахаав бүсгүй шиг) санаа зовж байгаа болон Хинааны хотуудын зайлшгүй сүйрэл, Лоотын удам угсаа болох Муабчууд, Аммунчуудтай тогтоосон тэдний харилцаа зэрэг тухайн үеийн хүмүүст тохиолдох зүйлийг ойлгоход нь Израйлчуудад тусалсан юм.

Аврахаамын бусад хүмүүстэй харилцсан хожмын харилцаа гэсэн энэ үеийн хоёрдахь хэсэг нь 20-р бүлгийн 1-ээс 18-д байдаг. Энэ түүхэнд Аврахаам дахиад л тухайн нутагт суудаг Пилэшэт овог аймгийн Аби-Мэлэх гэдэг хүний төлөө Ертөнцийн Эзэнээс зуучлан гуйдаг. Аби-Мэлэх нь Сараахыг Аврахаамын эхнэр гэдгийг мэдэлгүй авч түүний ирээдүйд заналхийлдэг билээ. Тэгэнгүүт Ертөнцийн Эзэн Аби-Мэлэхийг шийтгэх болдог. Харин Аби-Мэлэх хийсэн үйлдлээ хүлээн зөвшөөрч өөрийнхөө зөвийг нотолдог. Нэгэнт Аби-Мэлэх гэм буруугаа хүлээн зөвшөөрсөн учраас түүний төлөө Аврахаам Ертөнцийн Эзэнтэй зуучлан ярьдаг.

Тэгэхлээр энэ түүх нь Мөшэхтэй хамт амьдарч байгаа Израйльчуудад тухайн үеийн Пилэшэт хүмүүст хэрхэн хандах тухай хэлж байна. Энэ Пилэшэт хүмүүс янз бүрийн байдлаар Израйлийн ард түмэнд заналхийлж байсан. Харин Пилэшэт хүмүүст ирэх Ертөнцийн Эзэний шийтгэл нь тэднийг гэм буруугаа ойлгоход хүргэж улмаар Израйльчууд тэдний төлөө зуучлан ярьсанаар тэд хоорондоо өнө мөнх амар жимэр аж төрөх юм.

Харин энэ үеийн гуравдахь хэсэг нь 21-р бүлгийн 1-аас 21-д гарах бөгөөд Яйцхаах, Яйшмагийл хоёрын төвөгтэй харилцаан дээр голлон анхаардаг. Ингээд тэдний зөрчил улам хурцдахад Ертөнцийн Эзэн Яйшмагийлийг гэр бүлээсээ тусгаарлах зааварыг Аврахаамд өгдөг. Хэдийгээр Ертөнцийн Эзэн Яйшмагийлийг ивээсэн хэвээр байсан ч Яйцхаах бол Аврахаамын цорын ганц жинхэнэ өв залгамжлагч гэдгийг маш тодорхой болгодог юм. Мөшэх анхны Израйль уншигчдадаа энэ бүх үйл явдлыг мэдээлэхдээ тэдэнд тухайн үеийнхээ Яйшмагийлийн удам угсаатай харилцах харилцааны мөн чанарыг ойлгоход тусалдаг. Улмаар Яйшмагийлийн удам болон Израйльчуудын хоорондын зөрчил улам хурцдахад Ертөнцийн Эзэн тэднийг тусгаарласныг Израйль хүмүүс санасан байна. Хэдийгээр Ертөнцийн Эзэн Яйшмагийлийн удам угсааг янз бүрийн байдлаар ивээж байсан ч, Израйльчууд л Аврахаамын жинхэнэ өв залгамжлагч мөн билээ.

Энэ үеийн дөрөвдэхь хэсэг нь түүнийг Аби-Мэлэхтэй гэрээ байгуулсан талаар өгүүлдэг бөгөөд 21-р бүлгийн 22-оос 34-ийг хамардаг. Аврахаам Ертөнцийн Эзэний хайр хишгийг хүртсэнийг Пилэшэт хүн Аби-Мэлэх хэрхэн хүлээн зөвшөөрч байгаа, мөн тэд эв найрамдалтай амьдрахаар тохиролцсон зэргийг уг түүх өгүүлнэ. Хонин сүрэгтээ зориулан Аврахаамын ухсан худагтай холбоотой маргаан хэрхэн ширүүсэж, үүнээс болоод Аврахаам Аби-Мэлэх хоёр бие биенээ хүндэтгэн шударга харилцаж байх тангараг өргөж Бэйр-Шибя худгийн дэргэд албан ёсоор ёсоор гэрээ байгуулдаг

билээ.

Аби-Мэлэх болон түүний цэргийн жанжин хоёр тухайн үеийн Пилэшэт хүмүүсээс ирж болох аюулыг Мөшэхэд сануулж байна. Хэрэв Пилэшэт хүмүүс Израйльчуудад өгсөн Ертөнцийн Эзэний ивээлийг хүлээн зөвшөөрвөл Израйльчууд Аврахаамын жишээг дагаж тэдэнтэй эв найрамдалтай амьдрах болно гэж Мөшэх дагалдагчиддаа заасан юм. “Бэйр-Шибя” гэдэг нэртэй худаг Мөшэхийн үед ч байсан бөгөөд тэнд Израйльчуудтай гэрээ хийснийг, тэд хэрхэн Пилэшэт хүмүүстэй эв найрамдалтай байж, бие биенээ харилцан хүндэтгэхийг хичээх ёстойг тэдэнд сануулсаар байлаа. Ийнхүү бид “Бусад хүмүүстэй харилцсан Аврахаамын хожмын харилцаа” гэсэн түүхээс Мөшэх болон Израйльчуудтай учирч байсан хүмүүстэй холбоотой олон хүнийг олж үзлээ. Мөшэхийн үеийн Израйльчууд Аврахаамын хийсэн үйлдлийг ажиглаад ихийг сурч болох байв.

Үр хүүхдүүд ба үхэл

За одоо бүгдээрээ Аврахаамын амьдралын тухай Мөшэхийн бичсэн тэмдэглэлийн сүүлчийн үеийг үзэцгээе. Энэ бол 22-р бүлгийн 1-ээс 25-р бүлгийн 18-ийг хамарсан “Үр хүүхдүүд ба үхэл” гэсэн хэсэг юм. Энд гарах үйл явдлууд нь Ертөнцийн Эзэнтэй тогтоосон Аврахаамын гэрээний харилцаа ирээдүйн үеийг нь хамарч өргөжин тэлж байгааг өгүүлж, түүний өвд голлон анхаарсан байна. Ерөнхийдөө, Мөшэхээс энэ бүх түүхийг хүлээн авсан Израйльчууд өөрсдийгөө Аврахаамын өв залгамжлагчийн байр суурьтай гэдгээ мэдэж, үр хүүхдүүд нь хүртэл үүнийг өвлөн авна гэсэн найдвартай болох ёстой байлаа.

Аврахаамын амьдралын энэ үеийн эхний хэсэг нь 22-р бүлгийн 1-ээс 24-д гардаг. Энэ бол Аврахаамыг сорьсон тухай өгүүлдэг нөгөө алдартай хэсэг билээ. Энэ сорилт нь Аврахаамыг хүү Яйцхаахаасаа илүү Ертөнцийн Эзэнд хайртай эсэхийг шийдэх зорилготой байв. Ертөнцийн Эзэн Аврахаамыг хүүгээ өөрт нь өргөл болгон өргөх хэцүү сорилтонд оруулахаар дууддаг. Аврахаам үүнийг нь дуулгавартай биелүүлсэн тул Ертөнцийн Эзэн үүнийг нь харгалзан үзээд Яйцхаахад маш гэрэл гэгээтэй ирээдүйг бэлдсэнээ батлан хэлдэг билээ.

Энэ үйл явдал нь Мөшэхийг дагаж буй Израйльчуудад үй олон далд санааг хэлж болох юм. Гэхдээ үүний хамгийн чухал санаа бол Өөрт нь хир зэрэг үнэнч болохыг Ертөнцийн Эзэн харахын тулд Израйлийн ард түмнийг сорьж байна гэдгийг тэдэнд сануулсан явдал байлаа. Ертөнцийн Эзэн Мөшэхийн үеийн Израйльчуудыг маш олон сорилтонд оруулж байлаа. Харин Аврахаам Ертөнцийн Эзэнд дуулгартай байж сорилтоо давсан нь Израйльчуудад тэдний өмнө Түүний тавьсан ямар ч хэцүү сорилтыг даван туулах шаардлагатай байгааг нь сануулж өгсөн байна. Аврахаамын үр хүүхдийн нэг болох Яйцхаахын ялгуусан сайхан ирээдүй баталгаажсан явдал өөрсдийнх нь өмнө тулгарсан сорилтыг даван туулбал тэдэнд ч бас ийм сайхан ирээдүй байгааг Израйльчуудад сануулав.

За одоо Аврахаамын амьдралын энэ үеийн хоёрдахь хэсгийг үзэцгээе. Израйлийн энэ өвгийн оршуулгын өмч газартай болсон тухай түүх 23-р бүлгийн 1-ээс 20-д гардаг. Аврахаам эхнэр Сараахаа нас барсаны дараа хэрхэн Хэврүүн хотын

ойролцоо гэр бүлийн оршуулгын газартай болсон тухай энэ түүх өгүүлдэг. Уг хүүрнэл хэсэг нь Аврахаам энэ өмч газраа бэлэг болгож бус, худалдаж авсаныг онцлон харуулдаг билээ. Энэ өмч газрыг худалдаж авсан явдал нь Аврахаамын гэр бүлд Хинаан нутгийг эх орноо гэж үзэх хууль ёсны эрхийг тогтоож өгөв.

Мөшэхийг дагаж явсан Израйльчууд тэдний амьдралд зориулж энэ оршуулгын өмч газрыг худалдаж авсаны ач холбогдол болон далд санааг ойлгосон байна. Энэ бол тэдний өвөг дээдсийн оршуулгын газар юм. Аврахаам, Яйцхаах, Яахов нарыг бүгдийг нь тэнд хөдөөлүүлсэн ажээ. Тэд энэ нутгийг эзлэн авахаасаа өмнө үүнийг хууль ёсны өмч газар мөн гэж ойлгосон байна. Аврахаам, Яйцхаах, Яахов нар амьдралынхаа нэлээд их хугацааг Хэврүүн хотод эсвэл үүний эргэн тойронд өнгөрөөсөн байдаг. Израйльчууд Хэврүүнийг өөрсдийнхөө өвөг дээдсийн эх орон гэдэг үзлийг тууштай баримталж байсан. Түүгээр ч барахгүй тэд өвөг Яаховынхаа шарилыг Хэврүүнд оршуулах гэж Египетээс зөөж ирдэг билээ. Тэгэхлээр Аврахаам оршуулгын өмч газар худалдаж авсан тухай энэ түүх нь Хинаанчуудын нутгаас өөр түүний үр удам амьдрах ёстой зөв газар байхгүй гэдгийг харуулсан юм.

“Үр хүүхдүүд ба үхэл” гэсэн энэ үеийн гуравдахь хэсэгт Аврахаамын онцгой хүү Яйцхаахын эхнэр болох бэр Ривхаахын тухай өгүүлдэг. Энэ тухай 24-р бүлгийн 1-ээс 67-д гардаг билээ. Аврахаам Яйцхаахыг Хинаанчуудын ёс бус явдлын нөлөөнөөс холдуулахын тулд Хинаан эмэгтэйтэй гэрлэхгүй байхыг шаардаж байгаа тухай энэ түүх өгүүллэ. Гэхдээ Аврахаам Яйцхаахыг тэнд Ертөнцийн Эзэний амласан Хинаан нутагт үлдээгээд, түүнд эхнэр олуулахаар зарцыг нь явуулдаг. Аврахаам ийм арга замаар Яйцхаахад эхнэр олуулсанаараа Яйцхаах болон түүний удамд Ертөнцийн Эзэний агуу их ивээл баттай ирэхээр болгосон байна.

Мөшэхийг дагаж байгаа Израйльчууд өвөг эцэг Аврахаамтай нь холбох холбоос болсон Яйцхаах төрсөн нутаг Хинаандаа амьдарч байсан ч гэсэн Хинаанчуудын ёс бус амьдралтай хутгалдалгүй цэвэр ариун байж чадсан гэдгийг энэ түүхээс мэдэх авах ёстой байв. Тэд Амласан нутагт суурьшсан Хинаанчуудын ёс бус амьдралыг эсэргүүцсэн нөхцөлд л Яйцхаахын гэрэлт ирээдүй бас тэдний ч гэрэлт ирээдүй болох ёстой байв.

Аврахаамын амьдралын сүүлчийн хэсэг болох түүний нас барсан болон өв залгамжлалын тухай 25-р бүлгийн 12-оос 18-д өгүүлдэг. Үүнд Сараахаас бусад эхнэрээс нь гарсан Аврахаамын хүүхдүүдийн нэрийг жагсаасан хэд хэдэн товч баримт багтдаг. Цааш нь Аврахаам нас барсан болон тэрбээр амьд мэнд байхдаа хүү Яйцхаахаа өөрийн хууль ёсны өв залгамжлагч болгон сонгож эцсийн ерөөлөө айлдсан түүх гарна. Эцэст нь энэ бүхэн Яйшмагийлын удам угсааны товч жагсаалтыг дурдсан зөрчилдөөнтэй хэсгээр дуусдаг.

Аврахаамын амьдралыг ингэж төгсгөж байгаа нь анхны уншигчдад нэлээд олон далд санааг хэлж байна.

Аврахаамын бусад хүүхдийг Израйльчуудаас ялгахын тулд тэдний нэрийг жагсаасан юм. Мөшэхийг дагаж буй Израйльчууд нь Аврахаамд өгсөн амлалтыг өвлөх жинхэнэ өв залгамжлагчид мөн гэдгийг баттай болгохын тулд Яйцхаахад хэлсэн түүний эцсийн ерөөлийг тодруулж өгсөн. Мөн Яйшмагийлын удмынхан Аврахаамын өвөөс

хүртэх эрхтэй гэдэг мэдэгдэл хийж болзошгүй тул тэдний ийм санаархалыг үгүй хийхийн тулд нэрсийг нь дурдсан байна. Мөшэх Аврахаамын амьдралын тухай баримтыг ингэж төгсгөснөөрөө Амласан нутаг руу удирдан явж байгаа Аврахаамын жинхэнэ удам угсаа болсон Израйльчуудынхаа хэн болох, ямар эрх, үүрэг хариуцлагатай болохыг тогтоож өгсөн юм.

Тэгэхлээр Мөшэх удирдан явж байгаа Израйльчууддаа яагаад мөн хэрхэн Египет орныг нэг мөсөн орхиж, Ертөнцийн Эзэний амласан нутгийг эзлэн авахаар урагшлах ёстойг заахын тулд Аврахаамын амьдралын тухай түүхээ бичсэн гэдгийг бид харлаа. Энэ зорилгоо биелүүлэхийн тулд Израйльчууд хэрхэн Аврахаамд өгсөн Ертөнцийн Эзэний хайр өршөөлийг өвлөн авах болсон, түүнтэй адил Ертөнцийн Эзэнд үнэнч байх үүрэг хариуцлага хүлээснийг, Ертөнцийн Эзэний ивээлийг хэрхэн хүртэж, хэзээ нэгэн цагт тэд хэрхэн энэ дэлхийн ард түмэнд ивээл болох гэх мэт түүний амьдралын хэсэг бүрийг Мөшэх янз бүрийн байдлаар онцлон бичсэн байна. Ийнхүү Израйлийн энэ өвгийн амьдралын тухай өгүүлсэн Мөшэхийн тэмдэглэл нь түүнийг дагаж Амласан нутаг руу явж байсан Израйльчуудад тоо томшгүй олон далд санааг хэлж өгсөн юм.

ДҮГНЭЛТ

Энэ хичээлээр бид Эхлэл номонд өгүүлсэн Аврахаамын амьдралын тухай тэмдэглэлийн эх утгыг үзлээ. Бид энэ эх утгыг хоёр гол чиглэлээр судалсан билээ. Нэг талаар бид, Мөшэх эдгээр түүх болон энэ бүхнийг хандан бичсэн Израйльчуудынхаа туулж буй амьдралыг хооронд нь хэрхэн холбосныг судалсан. Нөгөө талаар бид, Мөшэх энэ бүх түүхийг хэрхэн анхны уншигчдадаа Египетийг ардаа орхиж, Хинан нутгийн эзлэн авахаар урагшлахад нь нөлөө үзүүлэхээр зохиомжлон бичсэнийг үзсэн билээ.

Бид Аврахаамыг анхны Израйль уншигчидтай Мөшэх холбож өгч байгааг болон энэ бүх түүх тэдэнд ямар нөлөө үзүүлэх ёстой байсан талаар илүү ихийг сурч авлаа. Ингэснээр бид Аврахаамын амьдралын үе бүр нь зөвхөн Израйльчуудыг замчлах зорилготой байгаагүй гэдгийг олж мэдэж, улмаар энэ бүхнийг өнөөгийн амьдралдаа хэрхэн хэрэгжүүлж болох талаар илүү сайн ойлгох болно.

Др.Ричард Л. Прагг. (Host) is Co-Founder and President of Third Millennium Ministries. He served as Professor of Old Testament at Reformed Theological Seminary for more than 20 years and was chair of the Old Testament department. An ordained minister, Dr. Pratt travels extensively to evangelize and teach. He studied at Westminster Theological Seminary, received his M.Div. from Union Theological Seminary, and earned his Th.D. in Old Testament Studies from Harvard University. Dr. Pratt is the general editor of the NIV Spirit of the Reformation Study Bible and a translator for the New Living Translation. He has also authored numerous articles and books, including *Pray with Your Eyes Open*, *Every Thought Captive*, *Designed for Dignity*, *He Gave Us Stories*, *Commentary on 1 & 2 Chronicles* and *Commentary on 1 & 2 Corinthians*.

ҮГСИЙН ТАЙЛБАР

урдчилан хэлсэн (adumbrate) – өмнө нь байсан хүмүүс, юмс, үйл явдлууд нь хожмын хүн, юмс, үйл явдлыг хэрхэн урьдчилан зөгнөж буйг тодорхойлоход хэрэглэгддэг "урьдчилсан дохио" эсвэл "урьдач дүрслэл"

Хинаан нутаг (Canaan, land of) – Ертөнцийн Эзэнтэй байгуулсан гэрээний дагуу Аврахам болон түүний үр удамд өгөгдөхөөр амласан нутаг. Өнөөгийн Израил улсын нутаг дэвсгэр болон Палестиний нутаг, Ливи, Иордан, болон Газар дундын эргийн дагуу нутаг мөн Египет Сирийн зарим хэсэг энд багтдаг.

Хинаанчууд (Canaanites) – Хамийн хүү Хинааны үр удам. Ешуугаа Хинаан орныг эзлэхээс өмнө тэнд амьдарч байсан хүмүүс.

Хөвч хөндөлт (circumcise/circumcision) – эрэгтэй хүний бэлэг эрхтний тээрхийн арьсыг огтолж авдаг Еврей заншил. Энэ заншлийг Ертөнцийн Эзэн тэдэнтэй хийсэн гэрээгээ батлан тамгалах зорилгоор тогтоосон тухай Эхлэл 17:10-14 дээр бий.

гэрээ (covenant) – Хоёр хүн эсвэл бүлэг хүмүүсийн хооронд, мөн Бурхан аливаа хүн ба бүлэг хүмүүстэй байгуулсан заавал биелүүлэх үүрэг бүхий хууль ёсны хэлцэл

Гэтлэл (exodus) – Израил ард түмэн Египетийн боолчлолоос чөлөөлөгдсөн үйл явдал.

урьдчилсан дохио (foreshadow) – Түүхэнд ирээдүйд гарцаагүй болох үйл явдлыг өнөөдөр урдчилан дүрсэлж буй уран зохиолын арга барил.

Хэврүүн (Hebron) – Сараах, Аврахам, Яйцхаах, Иахов нарыг оршуулсан газар. Хинаан байдаг хотын нэр.

Муабчууд (Moabites) – Мөшэхийн цаг үед Израилчуудтай харилцаа тогтоосон Лоотын үр удмынхан. Ертөнцийн Эзэн Израилчуудад тэдэнтэй бүү муудалцаж дайн өдөөрэй гэсэн байдаг.

Пэризи аймаг (Perizzites) – Аврахамын цаг үед Хинаан оронд амьдарч байсан нэг бүлэг хүмүүс.

Ривхаах (Rebekah) – Яйцхаахын эхнэр. Яахов Исаав хоёрын эх.

тэр ертөнц (that world) – Библийн бичээчдийн түүхийг нь бичиж буй дэлхий ертөнц

тэдний ертөнц (their world) – Бичвэрийн уншигчдын амьдарч байгаа цаг хугацаа, дэлхий ертөнц